

**ХҮН АМ ОРОН СУУЦНЫ  
2000 ОНЫ  
УЛСЫН ТООЛЛОГО**

**ТӨВ АЙМГИЙН  
ТООЛЛОГЫН ДҮН**

Монгол Улсын Үндэсний  
Статистикийн Газар

	<b>АГУУЛГА</b>	1
		<b>Хуудасны дугаар</b>
	<b>ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ</b>	<b>2-5</b>
	<b>ӨМНӨХ ҮГ</b>	<b>6</b>
<i>Бүлэг 1.</i>	<b>ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2000 ОНЫ УЛСЫН ТООЛЛОГЫГ ТӨВ АЙМАГТ ЗОХИОН БАЙГУУЛЖ ЯВУУЛСАН ТУХАЙ</b>	<b>7</b>
1.1	<b>Хүн ам, орон сууцны тооллого</b>	<b>7</b>
1.2	Тооллогын бэлтгэл ажлын үед хийсэн ажлууд	7
1.2.1	Тооллогын ажлыг орон нутагт удирдан явуулах орон тооны бус комисс, түр товчоо, тэдгээрийн бүтэц бүрэлдэхүүн	7
1.2.2	Аймгийн тооллогын комисс, түр товчооноос тооллогын бэлтгэл ажлыг хангах талаар төлөвлөж, гүйцэтгэсэн ажил	8
1.2.3	Тооллогын ажилтны сургалт	8
1.2.4	Өрх, хүн амын бүртгэл	8
1.3	Тоолох үед зохион байгуулж хийсэн ажил	9
1.4	Хүн ам, орон сууцны тооллогын төсвийн зарцуулалт	9
Бүлэг 2.	<b>ХҮН АМЫН ТОО, СУУРЬШИЛ, НЯГТРАЛ</b>	<b>10-12</b>
Бүлэг 3.	<b>ХҮН АМ ЗҮЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД</b>	<b>13-17</b>
Бүлэг 4.	<b>УЛСЫН ХАРЪЯАЛАЛ, ЯС ҮНДЭС</b>	<b>18</b>
Бүлэг 5.	<b>ДОТООД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН</b>	<b>19-25</b>
Бүлэг 6.	<b>БОЛОВСРОЛ, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ</b>	<b>26-34</b>
Бүлэг 7.	<b>ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИ</b>	<b>35-41</b>
Бүлэг 8.	<b>ӨРХ, ОРОН СУУЦНЫ ТӨРӨЛ, НӨХЦӨЛ</b>	<b>42-52</b>
Хавсралт 1.	<b>ТООЛЛОГОД ХЭРЭГЛЭСЭН ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ</b>	<b>53-56</b>

## **ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ**

		<i>Хуудасны дугаар</i>
Хүснэгт 2.1	Хүн амын тоо, тооллого явагдсан оноор	10
Хүснэгт 2.2	Хот, хөдөөгийн хүн амын эзлэх хувь, 2000 он	11
Хүснэгт 2.3	Аймгийн нийт хүн амд сум, төв суурин, хөдөөгийн хүн амын эзлэх хувь, 1989-2000 оны жилийн өсөлт, бууралт	11
Хүснэгт 2.4	Сумдын хүн амын тооны бүлэглэлт, 2000 он	12
Хүснэгт 2.5	Сумдын хүн амын нягтрал, 2000 он	12
Хүснэгт 3.1	Хүн амын тоо, нас, хүйсээр, 2000 он	13
Хүснэгт 3.2	Хүн амын нас, хүйсийн бүтэц, 1979, 1989, 2000 он	14
Хүснэгт 3.3	Арван найм, түүнээс дээш насны хүн амын гэрлэлтийн байдал, 1979, 1989, 2000 он	15
Хүснэгт 3.4	Гэрлэлтийн байдал, хүйсээр, 2000 он	15
Хүснэгт 3.5	Анхны гэрлэлтийн дундаж нас, 1989, 2000 он	16
Хүснэгт 3.6	Арван тав, түүнээс дээш насны хүн амын гэрлэлтийн байдал, насны бүлэг, хүйсээр, 2000 он	16
Хүснэгт 4.1	Ястан, үндэстэн, 1989, 2000 он	18
Хүснэгт 5.1	Төв аймгийн хүн амын шилжих хөдөлгөөн	19
Хүснэгт 5.2	Төв аймагт төрснөөс хойш амьдарч байгаа, шилжин ирсэн хүн ам, хүйсээр	20
Хүснэгт 5.3	Төв аймагт байнга оршин суугаа хүн ам төрсөн аймаг, нийслэл, хүйсээр	20
Хүснэгт 5.4	Төв аймгийн төрснөөс хойших шилжих хөдөлгөөн	21
Хүснэгт 5.5	Төв аймагт шилжиж ирсэн хүн ам байнга оршин суугаа, хугацаагаар	22
Хүснэгт 5.6	Төв аймгийн хүн амын таван жилийн шилжих хөдөлгөөн	24

Хүснэгт 5.7	Төв аймгийн хүн амын сүүлийн нэг жилийн шилжих хөдөлгөөн	25
Хүснэгт 6.1	Арав, түүнээс дээш насны хүмүүсийн бүтэц, боловсролын байдал, дүнд эзлэх хувь, хүйсээр, 1989, 2000 он	26
Хүснэгт 6.2	Долоо, түүнээс дээш настай хүн амын тоо, боловсролын байдал, хүйс, байршлаар, 2000 он	27
Хүснэгт 6.3	Долоо, түүнээс дээш насны хүн амын тоо, бүтэц боловсролын байдал, насны бүлэг, хувиар, 2000 он	28
Хүснэгт 6.4	Долоо, түүнээс дээш насны хүн амын тоо, бүтэц, боловсролын байдал, сумаар, 2000 он	29
Хүснэгт 6.5	Арван тав, түүнээс дээш насныхун амын бичиг үсгийн мэдлэг, хүйс, байршлаар, 2000 он	30
Хүснэгт 6.6	7-29 насны хүн амын сургуульд хамрагдалт, нас, насны бүлгээр, 2000 он	31
Хүснэгт 6.7	7-29 насны нийт хүн амд сургуульд суралцаж байгаа хүний эзлэх хувь, насны бүлэг, байршил, хүйсээр, 2000 он	32
Хүснэгт 6.8	Сургуульд суралцдаггүй 8-15 насны хүүхдийн тоо, сургуульд хамрагдалт, 2000 он	32
Хүснэгт 6.9	8-15 насны хүн амын сургуульд хамрагдалт, сумаар, 2000 он	33
Хүснэгт 7.1	Хүн амын эдийн засгийн идэвхийн байдал, хот, хөдөө, хүйсээр, дүнд эзлэх хувиар, 2000 он	35
Хүснэгт 7.2	Ажиллах хүч, эдийн засгийн идэвхигүй хүн ам, насны бүлэг, хүйсээр, 2000 он	36
Хүснэгт 7.3	Ажиллах хүч, хот, хөдөө, хүйсээр, 2000 он	37
Хүснэгт 7.4	Хүн амын ажил эрхлэлтийн түвшин, хүйс, хот, хөдөөгөөр, 2000 он	38
Хүснэгт 7.5	Ажил эрхэлдэг хүн ам, ажил эрхлэлтийн түвшин, насны бүлэг, хүйсээр, 2000 он	38
Хүснэгт 7.6	Ажил эрхэлдэг хүн ам, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбар, хүйсээр, 2000 он	39

Хүснэгт 7.7	Ажил эрхэлдэг хүн ам, ажил эрхлэлтийн байдал, хүйсээр, 2000 он	39
Хүснэгт 7.8	Ажилгүйчүүдийн тоо, ажилгүйдлийн түвшин, хүйс, хот, хөдөөгөөр, 2000 он	40
Хүснэгт 7.9	Эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо, ажил эрхлээгүй байгаа шалтгаан, хүйсээр, 2000 он	41
Хүснэгт 8.1	Өрхийн тоо, хот, хөдөөгөөр, 1989, 2000 он	42
Хүснэгт 8.2	Өрхийн тоо, өрхийн хэлбэр, хот, хөдөөгөөр, 2000 он	42
Хүснэгт 8.3	Өрхөд тоологдсон хүний тоо, нэг өрхөд ногдох хүний тоо, сумдаар, 2000 он	43
Хүснэгт 8.4	Өрхийн сууцны төрөл, хот, хөдөөгөөр, 2000 он	44
Хүснэгт 8.5	Өрхийн сууцны эзэмшил, хот, хөдөөгөөр, 2000 он	44
Хүснэгт 8.6	Өрхийн сууцны төрөл, сумдаар, гэрт суудаг өрх, ханын тоогоор, 2000 он	45
Хүснэгт 8.7	Өрхийн цахилгаан болон телефон утасны хангамж, хот, хөдөөгөөр, 2000 он	45
Хүснэгт 8.8	Байшинд амьдардаг өрх, сууцны зориулалт, хот, хөдөөгөөр, 2000 он	46
Хүснэгт 8.9	Байшинд амьдардаг өрх, өрхөд тоологдсон хүний тоо, сууцны талбайгаар, 2000 он	47
Хүснэгт 8.10	Байшинд амьдардаг өрхийн халаалт, усан хангамж, хот, хөдөөгөөр, 2000 он	47
Хүснэгт 8.11	Байшинд амьдардаг өрхийн сууцны нөхцөл, хот, хөдөөгөөр, 2000 он	48
Хүснэгт 8.12	Байшинд амьдардаг өрхийн хог зайлуулалт, хот, хөдөөгөөр, 2000 он	49
Хүснэгт 8.13	Байшинд амьдардаг өрхийн цахилгаан болон телефон утасны хангамж, 2000 он	49
Хүснэгт 8.14	Гэрт амьдардаг өрх, өрхөд тоологдсон хүний тоо, гэрийн ханын тоогоор, 2000 он	50
Хүснэгт 8.15	Гэрт амьдардаг өрх, ахуйн нөхцөл, байршлаар, 2000 он	50
Хүснэгт 8.16	Гэрт амьдардаг өрхийн эзлэх хувь, сумдаар, ахуйн нөхцлөөр, 2000 он	51
Хүснэгт 8.17	Гэрт амьдардаг өрхийн усан хангамж, байршлаар, 2000 он	52
Хүснэгт 8.18	Гэрт амьдардаг өрхийн цахилгаан болон телефон утасны хангамж, 2000 он	52
Зураг 2.1	Тооллого хоорондын хүн амын жилийн дундаж өсөлт, хувиар	10
Зураг 3.1	Хүн амын нас, хүйсийн суврага, 1989, 2000 он	14
Зураг 3.2	Бэлбэсэн хүн ам, нас, хүйсээр, 2000 он	17

Зураг 5.1	Төв аймгийн байнга оршин суугаа хүн ам, төрснөөс хойшхи шилжин ирэгсэд, насны бүлгээр, 2000 он	22
Зураг 5.2	Төв аймагт төрснөөс хойш шилжин ирэгсэд насны бүлэг, хүйсээр	23
Зураг 6.1	Долоо, түүнээс дээш насны хүн амын боловсролын түвшинг аймгуудын дундажтай зэрэгцүүлбэл, 2000 он	27
Зураг 6.2	Долоо, түүнээс дээш насны боловсролтой хүн ам, боловсролын түвшингээр, 2000 он	29
Зураг 6.3	Дээд боловсролтой хүн амын тоо, насны бүлэг, хүйсээр, 2000 он	30
Зураг 6.4	Арав, түүнээс дээш насны хүн амд бичиг үсэг мэддэг хүний эзлэх хувийг аймгуудын дундажтай харьцуулсан байдал, 2000 он	31
Зураг 6.5	Сургуульд суралцдаггүй 7-29 насны хүн амын тоо, насны бүлэг, хүйсээр, 2000 он	33
Зураг 6.6	8-15 насны хүн амын сургуульд хамрагдалт, хувиар, 2000 он	34
Зураг 7.1	Арван тав, түүнээс дээш насны хүн амын ажиллах хүчний оролцооны түвшин, 2000 он	35
Зураг 7.2	Арван тав, түүнээс дээш насны хүн амын ажиллах хүчний оролцооны түвшин, насны бүлэг, хүйсээр, 2000 он	37
Зураг 8.1	Өрхийн сууцны төрөл, 2000 он	44
Зураг 8.2	Өрхийн цахилгаан болон телефон утасны хангамж, 2000 он	46
Зураг 8.3	Байшинд амьдардаг өрхийн усан хангамж, 2000 он	48
Зураг 8.4	Байшинд амьдардаг өрхийн хог зайлуулалт, 2000 он	49
Зураг 8.5	Гэрт амьдардаг өрхийн ахуйн нөхцөл, 2000 он	52

## Өмнөх үг

Монгол Улсад 2000 онд явагдсан хүн ам, орон сууцны ээлжит тооллого нь XXI зууны эхэн дэх Монгол Улсын засаг захиргааны бүх нэгжийн хүн амын талаарх маш дэлгэрэнгүй мэдээллийг бүрдүүлсэн билээ. Иймээс энэхүү тооллогын мэдээллийг орон нутгийн хэрэглэгчдэд аль болох бүрэн хүргэх, аймаг, орон нутгийн хэмжээний бодлого, хөтөлбөр боловсруулахад өргөн ашиглах зорилгоор Үндэсний статистикийн газар нь Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэстэй хамтран НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр "Төв аймгийн хүн амын тооллогын дүн"-г хэвлүүлэн хэрэглэгчдэд танилцуулж байна.

Энэ тайлан нь 2000 оны хүн ам, орон сууцны тооллогыг Төв аймагт зохион байгуулж явуулсан тухай, хүн амын тоо, түүний тархан суурьшилт, хүн ам зүйн үзүүлэлт, ястан үндэстэн, боловсрол, бичиг үсгийн мэдлэг, шилжих хөдөлгөөн, хотжилт, ажил эрхлэлт, өрх, орон сууцны төрөл нөхцөл гэсэн 8 бүлгээс бүрдэнэ.

Энэхүү тайлангийн зэрэгцээ тооллогын үр дүнгийн гол хүснэгтүүдийг багтаасан эмхтгэлийг бүх аймаг болон нийслэл Улаанбаатар хотын дүнгээр, орон сууцны нөхцөлийн талаар бие даасан эмхтгэлийг улсын дүнгээр хэвлэж, нийтийн хүртээл болгож байна.

Энэхүү тайлан нь Төв аймгийн хүн амын тоо, түүний өөрчлөлт, тархан суурьшилт, боловсрол, ажил эрхлэлт, шилжих хөдөлгөөн, орон сууцны төрөл, нөхцлийн судалгааны чанартай мэдээллийг агуулж, аймгийн ойрын ирээдүйн хөгжил, хүн амын нийгмийн асуудлаар бодлого, хөтөлбөр боловсруулахад нэн хэрэгцээтэй чухал материал болсныг цохон тэмдэглэмээр байна.

Тайланг Австрали Улсын Засгийн газар болон НҮБ-ын Хүн амын сангаас үзүүлсэн санхүүгийн дэмжлэгтэйгээр бэлтгэн монгол хэл дээр хэвлүүлэв.

Энэхүү тайланг бэлтгэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн дарга Ж. Отгончулуун, мэргэжилтэн Д. Аюуш, тус хэлтсийн бусад ажилтнууд, ҮСГ-ын Хүн амын тооллого, судалгааны товчооны болон тус газрын Мэдээлэл боловсруулалт, программ хангамжийн газрын ажилтнуудад талархсанаа илэрхийлье.

### Ч. ДАВААСҮРЭН

Үндэсний статистикийн газрын дарга,  
Хүн ам, орон сууцны тооллогын улсын комиссын  
орлогч дарга

### М. МЭНДБИЛЭГ

Төв аймгийн Засаг дарга  
Төв аймгийн хүн ам, орон  
сууцны тооллогын  
комиссын дарга

# **Бүлэг 1: ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2000 ОНЫ УЛСЫН ТООЛЛОГЫГ ТӨВ АЙМАГТ ЗОХИОН БАЙГУУЛЖ ЯВУУЛСАН ТУХАЙ**

## **1. Хүн ам, орон сууцны тооллого**

Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллого нь тус улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих үеийн анхны тооллого учраас аргачлал, зохион байгуулалтын нэлээд онцлогууд байлаа. Өмнө нь явуулж байсан тооллогын арга зүйгээс нэлээд ялгаатай НҮБ-ын нэгдсэн арга зүйгээр явуулсанд оршино.

Ийнхүү хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогыг шинэ нөхцөл байдалд явуулахтай уялдан тооллогын үндсэн зорилго зарчмыг шинээр боловсруулах шаардлагатай болсон.

Хүн ам, орон сууцны тооллого явуулах хугацааг зөвшөөрөх тухай Монгол Улсын Их Хурлын 1998 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 06 дугаар тогтоол, Хүн ам, орон сууцны тооллого явуулах тухай Монгол Улсын засгийн газрын 1998 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 28 дугаар тогтоол гарч, уг тогтоолын аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасан 10 дугаар заалт нь орон нутагт хүн ам, орон сууцны тооллого явуулах эрх зүйн гол үндэслэл болсон.

## **2. Тооллогын бэлтгэл ажлын үед хийсэн ажлууд**

### **2.1 Зохион байгуулалтын ажил**

Хүн ам, орон сууцны тооллого явуулах тухай Монгол Улсын засгийн газрын 1998 оны 2 дугаар сарын 25 өдрийн 28 дугаар тогтоолын 10-ын “а” заалтыг үндэслэн Төв аймгийн хэмжээнд хүн ам, орон сууцны тооллогыг удирдан явуулах орон тооны бус комиссыг 1999 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 13 тоот захирамжаар 10 хүний бүрэлдэхүүнтэйгээр, мөн түүнчлэн тооллогын комиссын удирдлагын дор ажиллах түр товчоог аймгийн Засаг даргын 1999 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн 19 дүгээр захирамжаар 15 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллуулав.

Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогыг сумдад зохион байгуулж явуулах комиссуудыг 1999 оны 1 дүгээр улиралд багтаан байгуулж, сумдын тооллогын комиссын даргаар сумын Засаг дарга, комиссын гишүүдэд нь сумын Засаг даргын тамгын газар, багийн засаг дарга, бусад холбогдох албан тушаалтан 10-12 хүнийг оролцуулан томилж ажиллуулав.

Сумын тооллогын түр товчоог сумын орлогч даргаар даргалуулан гишүүдэд нь сумын санхүү, бүртгэл тооцооны зохих туршлагатай 4-7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан.



Хүн ам, орон сууцны тооллогыг нутаг дэвсгэрийн хэмжээнд бүрэн хамралттай, чанартай сайн явуулахад Засгийн газрын 1998 оны 28 дугаар тогтоолын 10-ын “д” заалтыг үндэслэн тоологч, шалгагч нарыг сонгож томилох ажил чухал нөлөөтэй байв. Тоологч, шалгагч нарыг Төв аймгийн хэмжээнд 1999 оны 11 дүгээр сард үндсэн нь сонгон шалгаруулж, томилсон юм.

## **2.2 Аймгийн тооллогын комисс, түр товчооноос тооллогын бэлтгэл ажлыг хангах талаар төлөвлөж, гүйцэтгэсэн ажил**

Хүн ам, орон сууцны тооллогын бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөөг 1998 оны 8 сарын 10-нд баталж тооллогын комиссын гишүүдийн ажил үүргийг нарийвлан гаргаж, хүн амыг тооллогод бүрэн хамруулах, тооллогын явцад хяналт тавих, тооллогын хуудасны асуулгаар иргэдээс үнэн зөв хариулт авахад ажлаа чиглүүлэн ажиллав.

## **2.3 Тооллогын ажилтны сургалтыг зохион байгуулж явуулсан байдал**

Төв аймаг сумдын түр товчооны дарга нарын нэгдсэн сургалтыг 1999 оны 11 дүгээр сарын 22-нд зохион байгуулж, сургалтанд сумдын түр товчооны дарга нар, аймгийн комиссын зарим гишүүд, түр товчооны ажилтан, Зуунмод сумаас нийт 63 хүнийг оролцуулан хийв.

Тооллогын хамгийн чухал сургалт бол ард иргэдээс асуулга авч, тооллого явуулах тоологч, шалгагч нарын сургалт байв. Тоологч, шалгагч нарын сургалтыг багш нарын нэг баг 3-4 сумыг тойрч хийхээр 8 хэсэг зохион байгуулж, 1999 оны 12 дугаар сарын 18-30-ны хооронд багтаан явуулж, сумын тоологч, шалгагч нарын 78.2-90.0 хувь нь буюу тоологч 569, шалгагч 125, сумын түр товчооны гишүүд 120, аймаг, сумдын тооллогын комиссын гишүүд 161 хүнийг хамруулав. Тоологч, шалгагч нарын сургалтыг сумдад зардал аль болох бага гарах, ойролцоо сумдыг нэг бүс болгон зохион байгуулж хийлээ.

## **2.4 Өрх, хүн амын бүртгэл, газрын зураглал**

Улсын хэмжээнд газрын зурагт шаардагдах өрх, хүн амын бүртгэлийг өөрийн орны онцлогт тохируулах, ялангуяа хөдөөгийн малчдыг өвөлжөөндөө бүрэн буусны дараа буюу мал тооллоготой хамт хийж байсан өмнөх тооллогын туршлагыг ашиглан хийлээ. Энэ нь хөрөнгө, хүч хэмнэх ихээхэн ач холбогдолтой байв. Өрх, хүн амын бүртгэлийг 1999 оны 12 дугаар сарын сүүлчээр бүрэн цэгцэлж дууссан байв. Ингэснээр тооллогод 23990 өрх, өрхөд тоологдох хүн ам 94849, нийтийн байранд тоологдох хүн ам 1495, бүгд 96344 хүнийг тооллогод хамруулахаар бүртгэсэн байв. Гэтэл тооллогын дүнгээр 101913 хүн тоологдож, 5569 хүнээр илүү гарсан байна.

Манай улсын өмнөх тооллогуудад газрын зургийг ашиглаж байсан боловч, энэ удаагийн тооллогод газрын зургийн ач холбогдлыг нэлээд өндөр үзэж, Засгийн газрын 1998 оны 28-р тогтоолын “г” заалтанд “Хүн ам, орон сууцны тооллого явуулахтай холбогдуулж хот, тосгон, сумын төв бусад суурин газрын гудамж талбайн нэр, хашаа байшингийн дугаарыг эмхлэн цэгцлэх, малчдын өвөлжиж байгаа газар нутгийг нарийвчлан тодорхойлох, тооллого явуулах нутаг дэвсгэрийн нь хил хязгаарыг тогтоон, зураглал гаргаж, Улаанбаатар хот, аймгийн төв, суурин газруудын нутаг дэвсгэрийн зураглалыг 1999 оны 9 дүгээр сард, бусад сум, багийн нутаг дэвсгэрийн зураглалыг 1999 оны 11 дүгээр сард багтаан Үндэсний статистикийн газар, холбогдох тооллогын комиссуудад хүргүүлсүгэй” гэж заасан билээ

Мөн түүнчлэн улсын хэмжээний хөдөөгийн сумын газрын зургийг нэг хэв загвар, масштабт оруулахын тулд Үндэсний статистикийн газар ARCVIEW багц программыг ашиглан АЗ цаасан дээр бүх сумын зургийг зурж 3 хувь үйлдэн орон нутагт хүргүүлсэн юм.

Төв аймгийн хувьд 1999 оны 12 дугаар сарын сүүлчээр өрх, хүн амын бүртгэл болон газрын зураглалыг бүрэн цэгцэлж дууссан болно.

### **3. Тоолох үед хийгдсэн ажил**

Төв аймгийн хувьд тооллогын хугацаанд аймгийн түр товчооны гишүүдийг 1 дүгээр сарын 5-наас эхлэн жижүүрлүүлэн, сумдаас тооллогын явцын мэдээг авч ҮСГ-т дамжуулж, аймгийн комиссын даргад өдөр тутам танилцуулж байв.

Тооллогын явцаас үзэхэд 1 сарын 10-ны байдлаар аймгийн хэмжээнд тоологдох өрхийн 84,3 хувь, хүний 86,0 хувь нь тоологдсон байв.

Тооллогын үеэр, ялангуяа тооллого эхэлсэн эхний 2 өдөр цасан шуургатай, хүйтний эрч эрс нэмэгдсэн нь бэрхшээл учруулж, шатахууны нормыг зарим суманд 30-50 хувь илүү зарцуулах тохиолодол гарч байв.

### **4. Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогын төсвийн зарцуулалт**

Тооллогод улсын төсвөөс Үндэсний статистикийн газраар дамжуулж **8480,0** мянган төгрөг олгосноос тоологч, шалгагч нарын урамшуулалд **92,7** хувийг, семинарын зардалд **620,0** мянган төгрөг зарцуулав. Мөн сумдууд тооллогод зориулан сумдынхаа төсвөөс **10671,0** мянган төгрөг зарцуулсан болно.

## Бүлэг 2: ХҮН АМЫН ТОО, СУУРЬШИЛ, НЯГТРАЛ

### Төв аймгийн хүн амын тоо, түүний өсөлт, тархан суурьшилт


Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогын дүнгээр Төв аймагт суурин хүн ам 99268 хүн байсны 51.8 хувь буюу 51374 нь эрэгтэй, 48.2 хувь буюу 47894 нь эмэгтэйчүүд байна. Нийт хүн амын 36.2 хувь нь 0-14 насны хүүхэд, 57.5 хувь нь 15-59 насны хүмүүс, 6.3 хувь нь 60 ба дээш насны хүн ам эзэлж байна.

#### Хүснэгт 2.1 Хүн амын тоо, тооллого явагдсан оноор

Тооллого явагдсан жилүүд	Хүн ам (мян.хүн)			Хүйсийн харьцаа
	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	
1956	29.1	26.1	55.2	111.5
1963	27.5	25.0	52.5	110.0
1969	33.1	30.5	63.6	108.5
1979	41.9	38.7	80.6	108.3
1989	51.1	49.0	100.1	104.3
2000	51.4	47.90	99.3	107.3

Төв аймгийн хүн ам 1979-1989 онд жилд дунджаар өсөлт 2.26 хувиар өсч байснаа 1989-2000 онд 0.05 хувь болж буурсан нь сүүлийн жилүүдэд төрөлт буурч, хүн амын шилжих хөдөлгөөн нэмэгдсэнтэй холбоотой юм. Төрөлтийн ерөнхий коэффициент 1989 онд 37.0, нас баралтынх 8.6, цэвэр өсөлтийнх 28.4 байсан бол 1999 онд төрөлтийнх 20.2 нас баралт 6.3, цэвэр өсөлт 13.9 болж буурчээ. Сүүлийн 1 жилд тус аймагт 5.2 мян.хүн шилжин ирж, 7.3 мян.хүн шилжин явж, аймгийн хүн амын тоо 2.1 мянгаар буурсан байна.

#### Зураг 2.1 Тооллого хоорондын хүн амын жилийн дундаж өсөлтийн хувь



## Хүснэгт 2.2 Хот, хөдөөгийн хүн амын эзлэх хувь, 2000 он

Байршил	Төв аймаг	Аймгуудын дундаж	Зөрүү
Хот	16.3	30.9	14.6
Хөдөө	83.7	69.1	-14.6

Аймгийн нийт хүн амын 16.3 хувь хот, тосгонд амьдарч байгаа нь аймгуудын дунджаас 14.6 пунктээр доогуур байна. Энэ нь тус аймаг Улаанбаатар хотод хамгийн ойр байдгаас нийслэл рүү шилжих хөдөлгөөн их байдагтай холбоотой гэж үзэж байна.

## Хүснэгт 2.3 Аймгийн нийт хүн амд сум, төв суурин, хөдөөгийн хүн амын эзлэх хувь, сумдын хүн амын 1989-2000 оны жилийн дундаж өсөлт, бууралт

Сумд	Хүн ам 2000	Аймгийн дүнд эзлэх хувь	1989-2000 оны жилийн дундаж өсөлт	Сумын хүн амд эзлэх хувь	
				Төв, суурин	Хөдөө
Алтанбулаг	3702	3.7	1.42	39.7	60.3
Аргалант	1988	2.0	-1.41	53.6	46.4
Архуст	2008	2.0	-1.04	40.2	59.8
Батсүмбэр	6537	6.6	0.22	36.1	63.9
Баян	3193	3.2	-0.97	75.5	24.5
Баяндэлгэр	2058	2.1	-3.02	46.7	53.3
Баянжаргалан	1789	1.8	2.04	54.7	45.3
Баян-Өнжүүл	2503	2.5	-0.4	17.7	82.3
Баянхангай	1710	1.7	-2.26	41.7	58.3
Баянцагаан	2724	2.7	1.51	30.7	69.3
Баянцогт	2430	2.4	-3.71	50.6	49.4
Баянчандмань	3458	3.5	-2.65	78.6	21.4
Борнуур	4206	4.2	-0.22	59.7	40.3
Бүрэн	3473	3.5	1.56	33.5	66.5
Дэлгэрхаан	2470	2.5	2.23	35.7	64.3
Жаргалант	5513	5.6	0.62	93.8	6.2
Заамар	6342	6.4	5.57	47.4	52.6
Лүн	3697	3.7	2.69	40.0	60.0
Мөнгөнморьт	2569	2.6	1.59	54.2	45.8
Өндөрширээт	2265	2.3	0.37	38.4	61.6
Сүмбэр	1982	2.0	0.11	81.6	18.4
Сэргэлэн	2005	2.0	-1.85	21.1	78.9
Угтаал	3534	3.6	-2.89	52.5	47.5
Цээл	3671	3.7	1.35	70.5	29.5
Эрдэнэ	3110	3.1	-3.07	28.1	71.9
Эрдэнэсант	5494	5.5	0.84	54.8	45.2
Зуунмод	14837	14.9	-0.6	100.0	-
Аймгийн дүн	99268	100	-0.07	58.1	41.9

Сумдын төв суурин, хөдөөгийн хүн амын харьцаа харилцан адилгүй, Баянчандмань, Жаргалант зэрэг сумдад төв, суурин газрын хүн амын эзлэх хувь харьцангуй өндөр байхад Бүрэн, Лүн, Эрдэнэ зэрэг сумдад хөдөөгийн хүн ам илүү байна.

Цээл, Заамар, Алтанбулаг, Лүн зэрэг сумууд Улаанбаатар хотод ойрхон зам харилцаа илүү сайтай зэргээс эдгээр суманд шилжин ирэгсдийн тоо олон байгаа нь хүн амын өсөлт нь нөлөөсөн байх талтай.

Заамар, Лүн, Дэлгэрхаан сумын хүн амын жилийн дундаж өсөлт 1989-2000 онд аймгийн бусад сумынхаас өндөр байна. Харин Баянцогт, Эрдэнэ, Баяндэлгэр, Угтаал сумын хүн ам 11 жилийн өмнөхөөсөө буурсан байна (Хүснэгт 2.3).

#### **Хүснэгт 2.4 Сумдын хүн амын тооны бүлэглэлт, 2000 он**

Хүн амын тооны бүлэглэлт	Бүлэгт багтах сумын тоо	Хүний тоо	Дүнд эзлэх хувь
> 2000	4	7469	7.5
2001 – 3000	9	21032	21.2
3001 – 4000	8	27838	28.0
4001 – 5000	1	4206	4.2
5001 – 6000	2	11007	11.1
6001 – 7000+	3	27266	27.9
Бүгд	27	99268	100.0

#### **Хүн амын нягтрал**

Төв аймагт нэг квадрат км-т 1.3 хүн ногдож байгаа нь улсын дунджаас (улсын дундаж 1.5 хүн) 0.2 хүнээр бага байна.

#### **Хүснэгт 2.5 Сумдын хүн амын нягтрал, 2000 он**

Хүн амын нягтрал	Сумдын тоо	Сумдын нэр
0.3-0.8	8	Мөнгөнморьт, Эрдэнэ, Баянцагаан, Сэргэлэн, Баян-Өнжүүл, Алтанбулаг, Баяжаргалан, Өндөрширээт
0.9-1.4	4	Баян, Дэлгэрхаан, Бүрэн, Баяндэлгэр
1.5-1.9	5	Эрдэнэсант, Лүн, Баянхангай, Баянцогт Аргалант
2.0-2.5	4	Архуст, Цээл, Заамар, Угтаал
2.6-3.1	2	Батсүмбэр, Жаргалант
3.2-3.7	1	Борнуур
3.8+	3	Баянчандмань, Сүмбэр, Зуунмод

Хүн амын нягтралаар Зуунмод хот хамгийн өндөр, 1 кв.км-т 773.8 хүн ногдож байгаа нь аймгийн төвд үйлдвэрлэл үйлчилгээ илүү хөгжсөн, тохилог орон сууцанд амьдрагсад олон байдагтай холбоотой. Зуунмод хотын дараа нягтралаараа Сүмбэр (5.7), Баянчандмань (5.6), Борнуур (3.7) орж байна. Мөнгөнморьт (0.38), Эрдэнэ (0.39), Баянцагаан (0.42) сумд хүн амын нягтрал багатай байна.

Улсын дунджаар 1 кв.км-т 1989 онд 1.3 хүн сууж байсан бол 2000 онд 1.5 болж өслөө. Харин Төв аймгийн хувьд өмнөх тооллогоор хүн амын нягтрал 1.33 байсан бол 2000 онд 1.34 болсон нь бараг өөрчлөлтгүй байна.

## Бүлэг 3: ХҮН АМ ЗҮЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

### Хүн амын нас, хүйсийн бүтэц

Төв аймагт хүн амын хүйсийн харьцаа нь 107.3 байгаа нь (100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо) улсын дунджаас ч (98.5), аймгуудын дунджаас ч нэлээд өндөр байна (Хүснэгт 3.1).


**Хүснэгт 3.1 Хүн амын тоо, нас хүйсээр, 2000 он**

Насны бүлэг	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа		
				Төв аймаг	Аймгуудын дундаж	Зөрүү
0-4	10221	5202	5019	103.6	102.7	-0.9
5-9	12098	6125	5973	102.5	102.7	0.2
10-14	13616	6896	6720	102.6	101.1	-1.5
15-19	10627	5838	4789	121.9	109.1	-12.8
20-24	9219	5055	4164	121.4	108.2	-13.2
25-29	8536	4550	3986	114.1	102.6	-11.5
30-34	7449	3818	3631	105.2	100.4	-4.8
35-39	6836	3525	3311	106.5	99.9	-6.6
40-44	5296	2693	2603	103.5	98.9	-4.6
45-49	3682	1862	1820	102.3	96.3	-6.0
50-54	2653	1324	1329	99.6	89.7	-9.9
55-59	2732	1410	1322	106.7	96.1	-10.6
60-64	2161	1132	1029	110.0	97.1	-12.9
65-69	1837	900	937	96.1	83.4	-12.7
70-74	955	462	493	93.7	77.6	-16.1
75-79	744	354	390	90.8	61.0	-29.8
80-84	341	128	213	60.1	46.6	-13.5
85+	265	100	165	60.6	40.3	-20.3
Дүн	99268	51374	47894	107.3	100.9	-6.4

Шинэ төрсөн 100 охидод 104-106 хөвгүүд ноогддог олон улсын нийтлэг жишиг байдаг бөгөөд энэ хандлага Монгол Улсад ч нэгэн адил байдаг. Шинэ төрсөн хүүхдийн хүйсийн харьцааны энэ онцлогоос хамааран 10-14 нас хүртэлх насны хүүхдийн дотор хөвгүүд арай давамгайлж, дараагийн насны бүлгүүдэд эрэгтэй, эмэгтэйчүүдийн хүйсийн харьцаа ойролцоо түвшинд, нас ахих тутамд эмэгтэйчүүд нь давамгайлдаг зүй тогтолтой байдаг. Төв аймгийн хүн амын хүйсний харьцааг аймгуудын дундажтай зэрэгцүүлэхэд нэлээд онцлогтой байгааг цаашид нарийвчлан судлах нь зүйтэй. Тухайлбал 65 нас хүртэл (50-54 наснаас бусад) бүх насны бүлгүүдэд хүйсийн харьцаа өндөр, үүний дотор 15-29 насанд эрэгтэйчүүд давамгайлсан байгаа нь шилжих хөдөлгөөнтэй холбон тайлбарлаж болох юм. Улсын хэмжээнд мэргэжлийн сургуульд суралцагчдын дийлэнх нь эмэгтэйчүүд байгаа нь залуу эмэгтэйчүүд нийслэлд суралцахаар шилжсэн болон тооллогоор аймгуудын нутагт байгаа хугацаат цэргийн албан хаагчдыг тухайн аймгийн хүн амд оруулсан зэргээс Төв аймгийн 15-29 насны хүйсийн харьцаа өндөр байхад голлон нөлөөлсөн гэж үзлээ.

Хүн амын насны бүтцийн өөрчлөлт нь төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөнтэй нягт уялдаатай байдаг. Эрэгтэй, эмэгтэй хүн амын насны бүтцийг 1989, 2000 оны байдлаар дараах зургаас харж болох юм.

**Зураг 3.1 Төв аймгийн хүн амын нас, хүйсийн суврага, 1989, 2000 он**



Суvрагаас харахад өнгөрсөн 11 жилд төрөлт эрс буурснаас 2000 онд 0-4, 5-9 насны хүмүүсийн тоо 10-14 насны хүн амаас цөөн байгаагаас суvрагын суурь нарийссан байна.

**Хүснэгт 3.2 Хүн амын нас, хүйсийн бүтэц, 1979, 1989, 2000 он**

Үзүүлэлт	1979 он	1989 он	2000 он
Хүн ам - Бүгд	79898	100088	99268
Эрэгтэй	41415	51076	51374
Эмэгтэй	38483	49012	47894
Насны бүлгээр			
0-14	36773	43254	35935
15-64	38912	51955	59191
65+	4213	4879	4142
Эрэгтэйчүүдийн эзлэх хувь	51.8	51.0	51.8
Эмэгтэйчүүдийн эзлэх хувь	48.2	49.0	48.2
Насны бүтэц, хувиар			
0-14	46.0	43.2	36.2
15-64	48.7	51.9	59.6
65+	5.3	4.9	4.2
15-49 насны эмэгтэйчүүд			
Хүйсийн харьцаа	107.6	104.2	107.3
Хүн ам зүйн ачаалал	105.3	92.6	67.7

Төв аймгийн хүн амын насны бүтэцэд сүүлийн 20 гаруй жилд багагүй өөрчлөлт оржээ (Хүснэгт 3.2). Нийт хүн амд 0-14 насны хүн амын эзлэх хувийн жин 2000 онд 1979 оныхоос 9.8, 1989 оныхоос 7.0 пунктээр тус тус буурч, харин 15-64 насны хүн амын эзлэх хувийн жин өссөн нь хүн ам зүйн ачааллыг (15-64 насны 100 хүнд ногдох 0-14, 65 ба дээш насны хүний тоо) бууруулахад хүргэв. Хүн ам зүйн ачаалал 2000 онд 1979 оныхоос 37.6, 1989 оныхоос 24.9 пунктээр тус тус буурсан байгаа нь эдийн засгийн өсөлтөд хүн ам зүйн хүчин зүйлийн нөлөө сайжирч байгааг харуулж байна.

## Гэрлэлт

Гэр бүлийн тухай Монгол Улсын хуулийн дагуу 18 нас хүрсэн иргэд албан ёсоор гэр бүл болох эрхтэй боловч олон улсын нийтлэг жишгээр гэрлэлтийн байдлын асуултыг 2000 оны тооллогоор 15 наснаас эхлэн асуусан. Гэвч өмнөх онуудтай зэрэгцүүлэхийн тулд хүснэгт 3.3-ыг 18-аас дээш насаар харуулав

### Хүснэгт 3.3 Арван найм, түүнээс дээш насны хүн амын гэрлэлтийн байдал, 1979, 1989, 2000 он

Гэрлэлтийн байдал	1979		1989		2000	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Огт гэрлээгүй	7974	20.5	11283	22.8	12510	22.2
Гэрлэсэн	26147	67.2	33336	67.3	38092	67.5
Салсан	736	1.9	890	1.8	1728	3.1
Бэлбэсэн	4033	10.4	4013	8.1	4136	7.2
Бүгд	38890	100.0	49522	100.0	56466	100.0

Төв аймгийн хүн амын гэрлэлтийн байдалд онц өөрчлөлт ороогүй. Нийт хүн амд огт гэр бүл болоогүй хүний эзлэх хувийн жин 2000 онд 1989 оныхоос 0.6 пунктээр буурч, харин салсан эрэгтэйчүүдийн тоо эмэгтэйчүүдийнхээс 158-аар цөөн байгаа нь гэр бүлээ цуцалсан эрэгтэйчүүдэд дахин гэрлэх боломж гарч болдогтой холбон тайлбарлаж болох юм (Хүснэгт 3.4).

2000 оны тооллогоор огт гэр бүл болоогүй эрэгтэйчүүдийн эзлэх хувийн жин 36.2, эмэгтэйчүүдийнх 24.2 хувь байгаа нь аймгуудын дундажтай харьцуулахад эрэгтэйчүүдийн эзлэх хувийн жин аймгуудын дундажтай нэг түвшинд, эмэгтэйчүүдийн эзлэх хувь 3.6 пунктээр доогуур байна.

### Хүснэгт 3.4 Арван тав, түүнээс дээш насны хүн амын гэрлэлтийн байдал, хүйсээр, 2000 он

Гэрлэлтийн байдал	Эрэгтэй			Эмэгтэй			Бүгд		
	тоо	Дүнд эзлэх хувь	Аймгуудын дундаж хувь	тоо	Дүнд эзлэх хувь	Аймгуудын дундаж хувь	тоо	Дүнд эзлэх хувь	Аймгуудын дундаж хувь
	Огт гэрлээгүй	12004	36.2	36.2	7313	24.2	27.8	19317	30.5
Гэрлэсэн <sup>1</sup>	19327	58.3	59.2	18825	62.3	59.3	38152	60.2	59.2
Салсан <sup>2</sup>	785	2.3	1.7	943	3.1	2.4	1728	2.7	2.1
Бэлбэсэн	1035	3.1	2.9	3101	10.2	10.5	4136	6.5	6.7
Бүгд	33151	100.0	100.0	30182	100.0	100.0	63333	100.0	100.0

<sup>1</sup>тогтмол хамтран амьдарч байгаа хүмүүсийг оруулсан

<sup>2</sup>Тусгаарласан хүмүүсийг оруулсан



Хүн амын гэрлэлт нь хүйсний бүтэцтэй уялдаатай байдаг бөгөөд анх гэрлэх үеийн нас хүйсний ялгаатай байдлыг анхны гэрлэлтийн дундаж нас гэсэн үзүүлэлтээр илэрхийлдэг.

### Хүснэгт 3.5 Анхны гэрлэлтийн дундаж нас, 1989, 2000 он

Тооллогын он	Төв аймаг		Улс		Аймаг-Улс /+,-/	
	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй
1989 он	24.9	22.3	23.3	21.1	1.6	1.2
2000 он	25.6	22.7	25.7	23.7	-0.1	-1.0

Төв аймгийн эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн анхны гэрлэлтийн насны ялгаа ойролцоогоор 2,6-2,9 насны зөрүүтэй байгаа нь улсын дунджаас 0,4-0,9 жилээр өндөр байна. 1989 оны тооллогоос хойших хугацаанд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн анхны гэрлэлтийн дундаж нас 0,4-0,7 жилээр нэмэгджээ.


### Хүснэгт 3.6 Арван тав, түүнээс дээш насны хүн амын гэрлэлтийн байдал, насны бүлэг, хүйсээр, 2000 он

Насны бүлэг	Эрэгтэй				Эмэгтэй			
	Огт гэрлээгүй	Гэрлэсэн	Салсан	Бэлбэсэн	Огт гэрлээгүй	Гэрлэсэн	Салсан	Бэлбэсэн
15-24	77.7	7.9	3.3	0.4	83.6	14.5	10.2	0.5
25-34	16.5	31.4	37.5	3.3	11.4	33.6	38.2	3.1
35-44	3.3	28.5	31.1	6.8	3.2	26.9	34.6	9.3
45-54	1.1	14.7	14.5	10.6	0.8	13.4	11.7	14.5
55-64	0.8	11.0	9.9	24.4	0.5	8.0	4.0	25.0
65 ба дээш	0.7	6.6	3.7	54.5	0.5	3.6	1.3	47.6
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0

Гэрлэлтийн байдлыг насны бүлгээр үзвэл огт гэрлээгүй эрэгтэйчүүдийн 77.7 хувь нь, эмэгтэйчүүдийн 83.6 хувь нь 15-24 насныхан байна. Нас дээшлэх тутам хүмүүс гэр бүл болж, огт гэр бүл болоогүй хүний эзлэх хувь буурч байна. 65, түүнээс дээш насны бүлэг дэх эрэгтэйчүүдийн 4,2 хувь, эмэгтэйчүүдийн 1,5 хувь нь огт гэрлээгүй байна.


Гэр бүл цуцлуулсан, тусгаарласан хүн амын тоо 25-44 насны бүлэгт хамгийн их буюу 1224 байгаагийн 64,2 хувийг эмэгтэйчүүд эзлэв.

**Зураг 3.2 Бэлбэсэн хүн ам, нас, хүйсээр, 2000 он**



Бэлбэсэн эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйчүүдийнхээс илүү олон байгаа нь эмэгтэйчүүдийн дундаж наслалт эрэгтэйчүүдийнхээс урт байдагтай холбон тайлбарлаж болох юм. 65, түүнээс дээш насны бүлэгт бэлбэсэн эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйчүүдийнхээс 913 хүнээр илүү байна.

**Зураг 3.3 Салсан хүн амын тоо, нас, хүйсээр, 2000 он**



Гэр бүл цуцлуулсан, тусгаарласан хүн амын тоо 25-44 насны бүлэгт хамгийн их буюу 1224 байгаагийн 56.0 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Харин бэлэвсрэлт нь нас ахих тусам илүү их ажиглагддаг гэж үздэг. 55-аас дээш насны бэлэвсэрсэн хүн 3173 байгаагийн 25.8 хувь нь эрэгтэйчүүд байна. Дахин гэрлэлт ямар нэг хэмжээгээр байдаг ч бэлэвсрэлтийн түвшин нь нас баралтын хүйсийн ялгаатай түвшинг илүү тусгадаг.

## Бүлэг 4: УЛСЫН ХАРЪЯАЛАЛ, ЯС ҮНДЭС

### Харъяалал

Төв аймагт байнга оршин сууж байгаа нийт хүн амын 99,8 хувийг Монгол Улсын харъяат иргэд, 0,2 хувийг гадаадын харъяат иргэд эзэлж байв. Төв аймагт нийт 20 орчим орны харъяат иргэд байнга оршин сууж байгаагийн 51,6 хувийг Оросын Холбооны Улсын иргэд, 10,1 хувийг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын иргэд эзэлж, үлдэх хэсэг нь бусад улсын иргэд оршин сууж байна.

Гадаадын харъяат иргэдийн 85,6 хувь нь Заамар суманд байнга оршин сууж байгаа нь энд үйл ажиллагаа явуулдаг гадаадын хөрөнгө оруулалттай алтны уурхайнуудад олон тооны гадаадын харъяат иргэд ажил эрхэлж байгаатай холбоотой. Бусад сумдад цөөн тооны гадаадын багш мэргэжилтнүүд байнга оршин сууж байна.

### Ястан, үндэстэн

Төв аймагт 30 орчим ястан, үндэстний төлөөлөгч оршин сууж байна (Хүснэгт 4.1). Нийт хүн амын 94,3 хувийг халх, 1,1 хувийг казах ястан эзэлж байна. Бусад ястан, үндэстнээс дөрвөд, баяд, буриад, урианхай, тува зэрэг ястан Төв аймагт байнга оршин суугаа бүх хүний 0,5-0,9 хувийг тус тус эзэлж байна. 1989 оноос хойш Төв аймгийн хүн амд ястан, үндэстний эзлэх хувийн жинд өөрчлөлт оржээ. Халх болон казах иргэдийн эзлэх хувь буурч, бусад ястаны эзлэх хувь өсчээ. Жишээлбэл, буриад ястан 1989 онд 0,6 хувийг эзэлж байсан бол 2000 онд 0,9 хувь болж, дөрвөд, баяд, урианхай ястаны эзлэх хувийн жин өсчээ. Энэ нь сүүлийн 10 жилд эрс нэмэгдсэн шилжих хөдөлгөөнтэй холбоотой.

### Хүснэгт 4.1 Ястан, үндэстэн, 1989, 2000 он

Ястан, үндэстэн	1989		2000	
	хүн ам	хувь	хүн ам	хувь
Нийт хүн ам	100088	100.0	99268	100.0
Халх	94773	94.6	93604	94.2
Казах	2167	2.2	1065	1.1
Буриад	590	0.6	856	0.9
Дөрвөд	727	0.7	770	0.8
Баяд	317	0.3	745	0.8
Урианхай	420	0.4	524	0.5
Тува	274	0.3	500	0.5
Захчин	160	0.2	202	0.2
Өөлд	61	0.1	171	0.2
Бусад	420	0.4	614	0.6
Монгол Улсын харъяат хүн	99909	99.8	99051	99.8
Гадаадын иргэд	179	0.2	217	0.2

## Бүлэг 5: ДОТООД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогод шилжих хөдөлгөөнийг тодорхойлохдоо нэг аймгаас, (Нийслэлээс) нөгөөд 6 сараас дээш хугацаагаар шилжин суурьшсан хүнийг хамруулсан. Ингэхдээ дотоод шилжих хөдөлгөөнийг 3 өөр аргаар илэрхийлэв. Эхнийх нь төрсөн аймаг, нийслэлээсээ тооллогын үед өөр аймаг, нийслэлд байнга оршин сууж байсан хүмүүсийг *төрснөөс хойш шилжигсэд* гэж үзсэн.

Шилжих хөдөлгөөнийг тодорхойлсон хоёр дахь арга нь тооллогын үед байнга оршин сууж байгаа газартаа амьдарсан хугацаа, хамгийн сүүлчийн шилжилтийн өмнө байнга оршин сууж байсан аймаг, нийслэлээр илэрхийлсэн. Эдгээрийн үр дүнд Төв аймагт шилжин ирэгсдийн дийлэнх олонх хаанаас ирсэн, хэдий хугацаанд амьдарч байгааг судлах боломж олгосон болно. Мөн сүүлийн нэг жилийн шилжих хөдөлгөөнийг тусад нь сугалж харуулсан.

Шилжих хөдөлгөөнийг судалсан гурав дахь арга нь таван жилийн өмнө байнга оршин сууж байсан аймаг, нийслэлийг үндэслэв.

Төв аймгийн хүн амын шилжих хөдөлгөөнийг өөр өөр цаг хугацаагаар авч үзэхэд шилжих хөдөлгөөнд орсон хүний тоо 5240-өөс 38105-ын хооронд хэлбэлзэж байна.

### Хүснэгт 5.1 Төв аймгийн хүн амын шилжих хөдөлгөөн

Шилжих хөдөлгөөний хугацаа	Шилжин ирэгсэд	Шилжин явагсад	Цэвэр шилжих хөдөлгөөн
Төрснөөс хойш	38105	36942	1163
Таван жилийн өмнөх	11169	15518	-4349
Сүүлийн нэг жил	5240	7305	-2065

Өөр аймаг, нийслэлд төрөөд Төв аймагт шилжин ирсэн хүний тоо тус аймагт төрөөд өөр аймаг, нийслэл рүү шилжин явсан хүний тооноос 1163 хүнээр илүү байгаа нь төрснөөс хойших шилжих хөдөлгөөний дүнд тус аймгийн хүн ам ийм хэмжээгээр нэмэгдсэнийг харуулав. Таван жилийн өмнө Төв аймагт амьдарч байсан 15518 хүн тооллогын үед өөр аймаг, нийслэл рүү шилжин явж, бусад аймаг, нийслэлээс энэ хугацаанд 11169 хүн Төв аймагт ирж суурьшсан байна. Таван жилийн шилжих хөдөлгөөний дүнд тус аймгийн хүн ам 4349 хүнээр цөөрчээ. Нэг жилийн шилжих хөдөлгөөний дүнд Төв аймгийн хүн ам 2065 хүнээр цөөрчээ.

## Төрснөөс хойших шилжих хөдөлгөөн

Төрснөөс хойших шилжих хөдөлгөөнд Төв аймагт төрөөд амьдралынхаа хугацаанд 6, түүнээс дээш сарын хугацаагаар шилжсэн бүх хүмүүсийг хамруулж байгаа юм (Хүснэгт 5.2).

Төв аймагт байнга оршин суугаа нийт 99268 хүн амын 61.6 хувь буюу 61163 хүн тус аймагт төрснөөс хойш амьдарч, үлдсэн 38.4 хувь буюу 38105 хүн бусад аймаг, нийслэлээс шилжин ирж суурьшсан байна.

**Хүснэгт 5.2 Төв аймагт төрснөөс хойш амьдарч байгаа болон шилжин ирсэн хүн ам**

Суурьшил, шилжилт	Байнга оршин суугаа хүн амын тоо			Дүнд эзлэх хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	99268	51374	47894	100.0	100.0	100.0
Төрснөөс хойш сууж байгаа	61163	29162	32001	61.6	56.8	66.8
Шилжиж ирсэн	38105	22212	15893	38.4	43.2	33.2

Төв аймагт тооллогын үед байнга оршин сууж байгаа хүн амын 72.6 хувь нь Төв аймагт, 5.9 хувь нь Улаанбаатар хотод, 2.5 хувь нь Говь-Алтай аймагт, Өвөрхангай аймагт 2.0 хувь нь, үлдсэн хэсэг нь эдгээрээс бусад аймагт төрсөн хүмүүс (Хүснэгт 5.3) юм. Баянхонгор, Дорноговь, Дорнод, Завхан, Өмнөговь, Сэлэнгэ, Дархан-Уул, Говьсүмбэр аймаг, Улаанбаатар хотод төрж, Төв аймагт шилжин суурьшсан хүмүүсийн дотор эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс олон, харин Говь-Алтай, Хэнтий аймгийн хувьд цөөн гарлаа.

## Хүснэгт 5.3 Төв аймагт байнга оршин суугаа хүн ам, төрсөн аймаг, нийслэл, хүйсээр

Төв аймагт төрөөд төрснөөсөө хойш тэндээ амьдарч байгаа 61163 хүн

Төрсөн аймаг, нийслэл	Байнга оршин суугаа хүн ам			Дүнд эзлэх хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	99268	51374	47894	100.0	100.0	100.0
Төв	72051	36688	35363	72.6	71.4	73.8
Улаанбаатар	5865	3311	2554	5.9	6.5	5.3
Завхан	3003	1596	1407	3.0	3.1	2.9
Говь-Алтай	2474	1232	1242	2.5	2.4	2.6
Архангай	1994	1090	904	2.0	2.1	1.9
Өвөрхангай	2032	1051	981	2.0	2.1	2.0
Увс	1658	898	760	1.7	1.7	1.6
Баянхонгор	1186	661	525	1.2	1.3	1.1
Сэлэнгэ	1044	582	462	1.1	1.1	1.0
Хөвсгөл	1087	583	504	1.1	1.1	1.1
Бусад	6874	3682	3192	6.9	7.2	6.7

(Хүснэгт 5.2), Төв аймагт төрсөн 72051 хүний зөрүү 10888 хүн нь Төв аймагт төрсөн боловч амьдралынхаа хугацаанд 6 сараас дээш хугацаагаар шилжих хөдөлгөөнд оролцоод буцаж нутагтаа ирсэн хүмүүс юм.

### Хүснэгт 5.4 Төв аймгийн хүн амын төрснөөс хойших шилжих хөдөлгөөн, аймаг, нийслэлээр

Аймаг, нийслэл	Шилжин ирэгсэд			Шилжин явагсад			Цэвэр шилжилт (Шилжин ирсэн, явсан хүний тооны зөрүү)	Дүнд эзлэх хувь
	Шилжин ирсэн хүний тоо	Шилжин ирэгсдийн хийсийн харьцаа	Дүнд эзлэх хувь	Шилжин явсан хүний тоо	Шилжин явагсдын хийсийн харьцаа	Дүнд эзлэх хувь		
Шилжигсэд - Бүгд	38105	139.8	100.0	36942	89.9	100.0	1163	
	Шилжих хөдөлгөөний сөрөг урсгал							
Улаанбаатар	15433	145.3	40.5	29258	87.9	79.2	-13825	89.9
Дархан-Уул	1210	127.9	3.2	2083	86.8	5.6	-873	5.7
Орхон	610	224.5	1.6	1025	89.8	2.8	-415	2.7
Говьсүмбэр	156	372.7	0.4	413	115.1	1.1	-257	1.7
Сөрөг урсгалын дүн	17409	-	45.7	32779	-	88.7	-15370	100.0
	Шилжих хөдөлгөөний эерэг урсгал							
Завхан	2279	106.2	6.0	58	123.1	0.2	2221	13.4
Говь-Алтай	1875	95.9	4.9	12	140.0	0.0	1863	11.3
Өвөрхангай	1786	106.0	4.7	225	104.5	0.6	1561	9.4
Архангай	1428	112.8	3.7	55	66.7	0.1	1373	8.3
Дорноговь	1986	351.4	5.2	618	117.6	1.7	1368	8.3
Увс	1252	112.9	3.3	29	81.3	0.1	1223	7.4
Дундговь	1036	82.1	2.7	87	85.1	0.2	949	5.7
Дорнод	1086	306.7	2.9	243	133.7	0.7	843	5.1
Бусад	7968	-	20.9	2836	-	7.7	5132	31.0
Эерэг урсгалын дүн	20696	-	54.3	4163	-	11.3	16533	100.0

Төв аймгийн хүн амын төрснөөс хойших шилжих хөдөлгөөний ерөнхий дүр төрх нь Улаанбаатар хот бусад томоохон хот руу шилжин явагсад шилжин ирэгсдээсээ илүү олон (шилжих хөдөлгөөний сөрөг урсгал), харин бусад аймгаас Төв аймагт шилжин ирэгсдийн тоо тэдгээр аймаг руу шилжин явагсдын тооноос илүү олон (шилжих хөдөлгөөний эерэг урсгал) байдаг байна. Шилжих хөдөлгөөний эерэг урсгалаар нэмэгдсэн хүн амын 50.7 хувь нь Завхан, Говь-Алтай, Өвөрхангай, Архангай, Дорноговь аймагт ногдлоо.


Шилжин ирэгсдийн бараг 60 хувь нь зөвхөн сүүлийн гурван жилд шилжиж иржээ. Зөвхөн сүүлийн нэг жил хүртэлх хугацаанд тус аймагт шилжин ирэгсдийн тоо сүүлийн гурван жилд шилжин ирэгсдийн 44.1 хувь болж байгаа нь Төв аймаг руу чиглэсэн шилжих хөдөлгөөн улам эрчимжиж байгаа, мөн ойрын ирээдүйд ч улам нэмэгдэж болзошгүйг харууллаа.

## Хүснэгт 5.5 Төв аймагт шилжиж ирсэн хүн ам байнга оршин суугаа Хугацаагаар

Байнга оршин суугаа хугацаагаар	Шилжин ирсэн хүний тоо			Хүйсийн харьцаа	Дүнд эзлэх хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй		Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	38105	22212	15893	139.8	100.0	100.0	100.0
1 жил хүртэл	5240	3489	1751	199.3	13.7	15.7	11.0
1-3 жил	6629	3776	2853	132.4	17.4	17.0	18.0
4-6 жил	4646	2527	2119	119.3	12.2	11.4	13.3
7-9 жил	3427	1961	1466	133.8	9.0	8.8	9.2
10-12 жил	3497	2087	1410	148.0	9.2	9.4	8.9
13-15 жил	2700	1542	1158	133.2	7.1	6.9	7.3
16-19 жил	3402	1890	1512	125.0	8.9	8.5	9.5
20 + жил	8564	4940	3624	136.3	22.5	22.3	22.8


Төв аймагт шилжин ирж суурьшсан хүмүүсийн 53.9 хувь нь хөдөлмөрийн насны, үүний дотор дийлэнх нь 20-39 насныхан байна (Зураг 5.1). Төв аймагт эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү олноороо шилжин ирж байгааг дээр дурьдсан билээ. Шилжин ирж суурьшсан 20-29 насны 100 эмэгтэйд 160-180 эрэгтэй ногдож байгаа нь эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү олноороо ирж суурьшсаныг харуулж байна (Зураг 5.2).

**Зураг 5.1 Төв аймгийн байнга оршин суугаа хүн ам, төрснөөс хойш шилжин ирэгсэд, насны бүлгээр**



Хүн амын тооллогын дүнг гаргахдаа тухайн аймгийн нутаг дэвсгэрт байгаа жагсаалын цэрэг, хоригдлуудыг аймгийн хүн амд оруулж гаргасан тул цэргийн анги, нэгтгэлүүдэд алба хааж байгаа залуучуудын тоогоор шилжих хөдөлгөөнд оролцогч эрэгтэйчүүд нэлээд нэмэгдсэн байж болох талтай.

**Зураг 5.2 Төв аймагт төрснөөс хойш шилжин ирэгсэд, насны бүлэг, хүйсээр**



### **Таван жилийн өмнөхтэй харьцуулсан шилжих хөдөлгөөн**

Таван жилийн өмнөхтэй харьцуулсан шилжих хөдөлгөөнийг 1995 оны 1 дүгээр сарын 1-нд байнга оршин сууж байсан аймаг, нийслэлийг үндэслэн тодорхойлсон.

Төв аймгийн тав, түүнээс дээш насны суурин хүн амын 87.5 хувь нь таван жилийн өмнө буюу 1995 оны 1-р сарын 1-ний байдлаар Төв аймагт амьдарч байжээ. Үлдсэн 12.5 хувь нь бусад аймаг, хотоос шилжин ирж суурьшжээ. Төв аймагт таван жилийн өмнө шилжин суурьшигсадын 35.9 хувь нь Улаанбаатар хотоос, 6.5 хувь нь Увсаас, 6.3 хувь нь Говь-Алтайгаас, 6.0 хувь нь Завханаас ирж суурьшсан байна (Хүснэгт 5.6). Дундговь аймгаас шилжин ирсэн 100 эмэгтэйд 104 эрэгтэй ногдож байхад Баянхонгор аймгаас шилжин ирсэн 100 эмэгтэйд 252 эрэгтэй ногдлоо. Ерөнхийдөө сүүлийн таван жилд шилжин ирэгсдийн дунд мөн л эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс олон байна.



## Хүснэгт 5.6 Төв аймгийн хүн амын таван жилийн өмнөхтэй харьцуулсан шилжих хөдөлгөөн, аймаг нийслэлээр

Аймаг, нийслэл	Шилжин ирэгсэд			Шилжин явагсад				
	Шилжин ирсэн хүний тоо	Шилжин ирэгсдийн хүйсийн харьцаа	Дүнд эзлэх хувь	Шилжин явсан хүний тоо	Шилжин явагсдын хүйсийн харьцаа	Дүнд эзлэх хувь	Цэвэр шилжилт (Шилжин ирсэн, явсан хүний тооны) Дүнд эзлэх хувь	
Шилжигсэд - Бүгд	11169	107.7	100.0	15518	99.0	100.0	-4349	
Шилжих хөдөлгөөний сөрөг урсгал								
Улаанбаатар	3988	146.2	35.9	12570	91.7	81.0	-8582	96.6
Дархан-Уул	412	145.2	3.7	539	92.5	3.5	-127	1.4
Орхон	219	121.2	2.0	308	115.4	2.0	-89	1.0
Сэлэнгэ	596	187.9	5.4	648	163.4	4.2	-52	0.6
Дорноговь	283	211.0	2.5	313	187.2	2.0	-30	0.4
Сөрөг урсгалын дүн	5498	-	49.5	14378	-	92.7	-8880	100.0
Шилжих хөдөлгөөний эерэг урсгал								
Говь-Алтай	693	107.5	6.3	5	66.7	0.0	688	15.2
Увс	710	127.6	6.5	32	220.0	0.2	678	15.0
Завхан	665	146.3	6.0	64	255.6	0.4	601	13.3
Архангай	404	143.4	3.6	34	70.0	0.2	370	8.2
Өвөрхангай	523	138.8	4.7	159	152.4	1.0	364	8.0
Дундговь	322	103.8	2.9	46	64.3	0.3	276	6.1
Хөвсгөл	269	166.3	2.4	38	90.0	0.2	231	5.1
Хэнтий	335	139.3	3.0	127	149.0	0.8	208	4.6
Ховд	243	138.2	2.2	37	516.7	0.2	206	4.5
Баянхонгор	190	251.9	1.7	11	57.1	0.1	179	4.0
Булган	386	114.4	3.5	219	92.1	1.4	167	3.7
Бусад	931	-	2.3	368	-	1.1	563	12.3
Эерэг урсгалын дүн	5671	-	50.5	1140	-	7.3	4531	100.0

Төв аймгийн 5 жилийн шилжих хөдөлгөөний ерөнхий дүр төрх нь төрснөөс хойшхи шилжих хөдөлгөөнтэй бараг адилхан байна. Шилжих хөдөлгөөний эерэг урсгалаар нэмэгдсэн хүн амын 59.7 хувь нь Говь-Алтай, Увс, Завхан, Архангай, Өвөрхангай аймагт ногдлоо.

### Сүүлийн нэг жилийн шилжих хөдөлгөөн

Төв аймагт сүүлийн нэг жилд шилжин ирэгсдийн буюу 38.5 хувь 2019 нь Улаанбаатар хот, 6.8 хувь нь Говь-Алтай, 5.6 хувь нь Завхан, Увс, 5.4 хувь нь Өвөрхангай, 4.0 хувь нь Дархан-Уул, аймгаас шилжин ирсэн нь бусад аймгийнхаас олон байна.

**Хүснэгт 5.7 Төв аймгийн хүн амын сүүлийн нэг жилийн шилжих хөдөлгөөн, аймаг, нийслэлээр**

Аймаг, нийслэл	Шилжин ирэгсэд			Шилжин явагсад			Цэвэр шилжилт (Шилжин ирсэн, явсан хүний тооныхы зөрүү)	Дүнд эзлэх хувь
	Шилжин ирсэн хүний тоо	Шилжин ирэгсдийн хүйсийн харьцаа	Дүнд эзлэх хувь	Шилжин явсан хүний тоо	Шилжин явагсдын хүйсийн харьцаа	Дүнд эзлэх хувь		
Шилжигсэд - Бүгд	5240	199.3	100.0	7305	103.3	100.0	-2065	
	Шилжих хөдөлгөөний сөрөг урсгал							
Улаанбаатар	2019	191.3	38.5	6138	96.1	84	-4119	98.8
Орхон	86	152.9	1.6	131	151.9	1.8	-45	1.1
Сэлэнгэ	268	362.1	5.1	271	150.9	3.7	-3	0.1
Сөрөг урсгалын дүн	2373	-	45.2	6540	-	89.5	-4167	100.0
	Шилжих хөдөлгөөний эерэг урсгал							
Говь-Алтай	354	105.8	6.8	2	100.0	0.0	352	16.7
Увс	292	139.3	5.6	11	450.0	0.2	281	13.4
Завхан	291	223.3	5.6	20	185.7	0.3	271	12.9
Өвөрхангай	285	196.9	5.4	84	171.0	1.1	201	9.6
Архангай	151	251.2	2.9	9	50.0	0.1	142	6.8
Дундговь	146	128.1	2.8	10	66.7	0.1	136	6.5
Баянхонгор	114	570.6	2.2	1	0.0	0.0	113	5.4
Хөвсгөл	112	348	2.1	10	150.0	0.1	102	4.8
Булган	169	116.7	3.2	75	108.3	1.0	94	4.5
Ховд	98	172.2	1.9	28	1300.0	0.4	70	3.3
Хэнтий	127	149	2.4	66	127.6	0.9	61	2.9
Дорнод	114	192.3	2.2	54	800.0	0.7	60	2.8
Бусад	614	-	11.718	395	-	5.4	211	10.0
Эерэг урсгалын дүн	2867	-	54.8	765	-	10.5	2102	100.0

Төв аймгийн хүн амын шилжих хөдөлгөөний ерөнхий дүр төрх цаг хугацааны байдлаас хамаарч нэг их өөрчлөгдөхгүй байна. Улаанбаатар хот бусад томоохон хот уруу Төв аймгаас шилжин явагсдын тоо тэндээс шилжин ирэгсдийнхээ тооноос илүү буюу шилжих хөдөлгөөний сөрөг урсгалтай, харин бусад аймгаас, түүний дотор Говь-Алтай, Архангай, Өвөрхангай зэрэг аймгаас шилжин ирэгсдийн тоо тэдгээр аймаг руу шилжин явагсдын тооноос илүү буюу эерэг урсгалтай байна.

## Бүлэг 6: БОЛОВСРОЛ, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ

Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогоор боловсрол, бичиг үсгийн мэдлэгийн талаар хоёр асуулт асуусан. Эхний асуулт нь суралцаж эзэмшсэн боловсролын дээд түвшин, бичиг үсгийн мэдлэгийн талаархи асуулт, хоёрдахь нь тооллогын үед боловсрол олгох сургуульд суралцаж байсан эсэхтэй холбоотой бөгөөд түүнийг 7-29 насны бүх хүмүүсээс асуусан. (Боловсрол, бичиг үсгийн мэдлэг, суралцагсадын талаарх тодорхойлолтыг тооллогод хэрэглэсэн ойлголт, тодорхойлолт гэсэн хавсралтаас үзнэ үү).

### Боловсролын түвшин

1989, 2000 оны тооллогын боловсролын асуулга, хариултууд яв цав нийлэхгүй боловч арав, түүнээс дээш насны хүмүүсийн боловсролын түвшинг нэгтгэж зэрэгцэхүйц болгож харуулав.

*Хүснэгт 6.1 Арав, түүнээс дээш насны хүмүүсийн бүтэц, боловсролын байдал, хүйс, дүнд эзлэх хувиар, 1989, 2000 он*

Боловсролын байдал	1989			2000		
	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Боловсролгүй	11.4	15.7	13.5	13.4	13.4	13.4
Боловсролтой	88.6	84.3	86.5	86.6	86.6	86.6
Үүнээс:						
Бага	33.3	34.6	33.9	26.9	25.5	26.2
Бүрэн бус дунд*	36.9	27.7	32.4	33.0	26.4	29.8
Бүрэн дунд, техник мэргэжлийн*	9.2	11.0	10.1	18.4	22.2	20.2
Тусгай мэргэжлийн дунд, бүрэн бус дээд	5.3	8.1	6.7	4.3	8.6	6.4
Дээд	3.9	2.9	3.4	4.0	3.9	4.0

*Тайлбар* \* 1989 оны тооллогод бүрэн бус дунд сургууль төгсөөд техник мэргэжлийн сургуульд суралцаж, мэргэжил эзэмшсэн (бүрэн дунд боловсрол эзэмшээгүй) хүмүүсийг бүрэн бус дунд боловсролтой оруулж байсан бол 2000 тооллогод техник мэргэжлийн сургууль төгсөгчдийг бүгдийг боловсролын нэг түвшинд хамааруулж бүрэн дунд боловсролтой хүний тоотой нэгтгэж оруулсан болно.


Дээд боловсролтой хүмүүсийн эзлэх хувь 1989 онд 3.4 байснаа 2000 онд 4.0 хувь болж өсч, харин бага боловсролтой хүмүүсийн эзлэх хувь 7.7 пунктээр буурснаас үзэхэд Төв аймгийн хүн амын боловсролын түвшин дээшилж байгааг харуулав.

*Хүснэгт 6.2 Долоо, түүнээс дээш настай хүн амын тоо, боловсролын байдал, хүйс, хот, хөдөөгөөр, 2000 он*

Боловсролын байдал	Хөдөө		Хот		Бүгд		Бүгд
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	
Бүгд	36864	33583	7124	7180	43988	40763	84751
Боловсролгүй	7894	7385	1419	1424	9313	8809	18122
Боловсролтой	28970	26198	5705	5756	34675	31954	66629
Үүнээс:							
Бага	9500	8147	1259	1258	10759	9405	20164
Бүрэн бус дунд	11462	8405	1752	1338	13124	9743	22957
Бүрэн дунд, тех- ник мэргэжлийн	5694	6471	1662	1721	7356	8192	15548
Тусгай мэргэжлийн дунд, бүрэн бус дээд	1315	2316	417	844	1732	3160	4892
Дээд	999	859	615	595	1614	1454	3068

Хот, хөдөөгийн хүн амын боловсролын түвшин нэлээд ялгаатай байна. Хөдөөгийн хүн амын 21.7 хувь нь боловсролгүй байхад хотын хүн амын 19.8 хувь нь боловсролгүй байгаагийн дээр бага боловсролтой хүн ам хөдөөгийн хүн амын 25.1 хувийг эзэлж байхад энэ үзүүлэлт хотод 17.5 хувь байна. Гэтэл хөдөөгийн хүн амын 2.6 хувь нь дээд боловсролтой байхад хотын хүн амын 8.5 хувь нь дээд боловсролтой байгаа нь хөдөөгөөс 5.9 пунктээр илүү байна.

*Зураг 6.1 Долоо, түүнээс дээш насны хүн амын боловсролын түвшинг аймгуудын дундажтай зэрэгцүүлбэл, 2000 он*



Төв аймгийн бүрэн бус дундаас дээш хүн амын эзлэх хувь аймгуудын дунджаас илүү байна.

### Хүснэгт 6.3 Долоо, түүнээс дээш насны хүн амын тоо, бүтэц, боловсролын байдал, насны бүлэг, дүнд эзлэх хувиар, 2000 он

Насны бүлэг	Бүгд		Боловсролгүй		Боловсролтой		Үүнээс:									
							Бага		Бүрэн бус дунд		Бүрэн дунд, ТМС		ТМД, бүрэн бус дээд		Дээд	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Бүгд	84751	18122	21.4	66629	78.6	20164	30.3	22957	34.5	15548	23.3	4892	7.3	3068	4.6	
7-9	7802	7802	100.0	-	0.0	-	0.0	-	0.0	-	0.0	-	0.0	-	0.0	
10-14	13616	6060	44.5	7556	55.5	7469	98.8	87	1.2	-	-	-	-	-	-	
15-19	10627	913	8.6	9714	91.4	3452	35.5	4557	46.9	1705	17.6	-	-	-	-	
20-24	9219	330	3.6	8889	96.4	1345	15.1	4402	49.5	2594	29.2	262	3.0	286	3.2	
25-29	8536	241	2.8	8295	97.2	420	5.1	3369	40.6	3515	42.4	677	8.1	314	3.8	
30-34	7449	206	2.8	7243	97.2	417	5.7	2688	37.1	2902	40.1	854	11.8	382	5.3	
35-39	6836	262	3.8	6574	96.2	678	10.3	2486	37.8	2039	31.0	870	13.3	501	7.6	
40-44	5296	167	3.2	5129	96.8	871	17.0	1989	38.8	1199	23.4	660	12.8	410	8.0	
45-49	3682	148	4.0	3534	96.0	860	24.4	1206	34.1	647	18.3	506	14.3	315	8.9	
50-54	2653	95	3.6	2558	96.4	716	28.0	752	29.4	411	16.1	390	15.2	289	11.3	
55-59	2732	215	7.9	2517	92.1	981	39.0	634	25.2	287	11.4	317	12.6	298	11.8	
60+	6303	1683	26.7	4620	73.3	2955	64.0	787	17.0	249	5.4	356	7.7	273	5.9	

Монгол улс хүн амынхаа боловсролыг дээшлүүлэх талаар урт удаан хугацаанд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд тухайн насны бүлгийн нийт хүн амд боловсролтой хүн амын эзлэх хувийн жин 15-60 хүртэл насны бүлэг тус бүрд 90-ээс дээш хувь болсон байна. Дээд, бүрэн бус дээд, тусгай мэргэжлийн дунд боловсролтой хүн амын эзлэх хувийн жин 35-49 насанд хамгийн өндөр байгаа нь манай улсын бүрэн дунд сургууль төгссөн хүмүүс 1960-1970 онд дээд, тусгай мэргэжлийн боловсрол эзэмших боломж илүү байсантай холбон үзэж болох юм.


Жараас дээш насны хүмүүсийн боловсролын түвшин доогуур, энэ насны бүлгийн боловсролтой нийт хүн амд бага боловсролтой хүний эзлэх хувийн жин 64.0 хувь байгаа нь бага боловсрол тухайн үеийн боловсролын хамгийн түгээмэл түвшин байсныг харууллаа.

### Хүснэгт 6.4 Долоо, түүнээс дээш насны хүн амын тоо, бүтэц, боловсролын байдал, сум, дүнд эзлэх хувиар, 2000 он

Сум	Бүгд		Боловсролгүй		Боловсролтой		Үүнээс:									
							Бага		Бүрэн бус		Бүрэн дунд,		ТМД, бүрэн		Дээд	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Бүгд	84751	18122	21.4	66629	78.6	20164	30.3	22957	34.5	15548	23.3	4892	7.3	3068	4.6	
Алтанбулаг	3114	656	21.1	2458	78.9	824	33.5	772	31.4	608	24.7	156	6.4	98	4.0	
Батсүмбэр	5578	1296	23.2	4282	76.8	1228	28.7	1583	37.0	979	22.9	319	7.4	173	4.0	
Баян	2826	445	15.7	2381	84.3	501	21.0	1162	48.8	516	21.7	145	6.1	57	2.4	
Баян-Өнжүүл	2100	387	18.4	1713	81.6	730	42.6	635	37.1	236	13.8	89	5.2	23	1.3	
Баяндэлгэр	1772	375	21.2	1397	78.8	467	33.4	540	38.7	264	18.9	77	5.5	49	3.5	
Баянжаргалан	1481	343	23.2	1138	76.8	407	35.8	447	39.3	187	16.4	72	6.3	25	2.2	
Баянцагаан	2304	429	18.6	1875	81.4	784	41.8	698	37.2	281	15.0	64	3.4	48	2.6	
Баянцогт	2039	472	23.1	1567	76.9	474	30.2	468	29.9	433	27.6	122	7.8	70	4.5	
Борнуур	3573	787	22.0	2786	78.0	801	28.7	942	33.8	721	25.9	217	7.8	105	3.8	
Бүрэн	2863	731	25.5	2132	74.5	948	44.5	694	32.5	327	15.3	123	5.8	40	1.9	
Дэлгэрхаан	2046	490	23.9	1556	76.1	702	45.1	572	36.8	199	12.8	61	3.9	22	1.4	
Жаргалант	4672	1107	23.7	3565	76.3	994	27.9	1247	35.0	907	25.4	272	7.6	145	4.1	
Заамар	5408	1112	20.6	4296	79.4	1162	27.0	1455	33.9	1122	26.1	352	8.2	205	4.8	
Лүн	3211	607	18.9	2604	81.1	819	31.4	1011	38.8	536	20.6	142	5.5	96	3.7	
Мөнгөнморьт	2213	474	21.4	1739	78.6	502	28.9	724	41.6	368	21.2	96	5.5	49	2.8	
Өндөрширээт	1874	369	19.7	1505	80.3	599	39.8	473	31.4	307	20.4	92	6.1	34	2.3	
Сэргэлэн	1676	346	20.6	1330	79.4	413	31	509	38.3	266	20.0	102	7.7	40	3.0	
Угтаал	3023	671	22.2	2352	77.8	722	30.7	896	38.1	497	21.1	148	6.3	89	3.8	
Эрдэнэ	2618	609	23.3	2009	76.7	706	35.1	721	35.9	373	18.6	138	6.9	71	3.5	
Эрдэнэсант	4584	1152	25.1	3432	74.9	1335	38.9	1062	30.9	745	21.7	196	5.7	94	2.8	
Баянчандмань	3014	586	19.4	2428	80.6	499	20.6	824	33.9	763	31.4	213	8.8	129	5.3	
Зуунмод	13125	2571	19.6	10554	80.4	2324	22.0	2816	26.7	3107	29.4	1161	11.0	1146	10.9	
Сүмбэр	1650	406	24.6	1244	75.4	332	26.7	443	35.6	324	26.1	95	7.6	50	4.0	
Цээл	3097	683	22.1	2414	77.9	747	30.9	835	34.6	612	25.3	151	6.3	69	2.9	
Архуст	1702	380	22.3	1322	77.7	430	32.5	431	32.6	321	24.3	102	7.7	38	2.9	
Аргалант	1710	359	21.0	1351	79.0	356	26.4	519	38.4	304	22.5	106	7.8	66	4.9	
Баянхангай	1478	279	18.9	1199	81.1	358	29.8	478	39.9	245	20.4	81	6.8	37	3.1	


Бүрэн, Эрдэнэсант, Сүмбэр, Дэлгэрхаан, Жаргалант сумдад 7, түүнээс дээш насны боловсролгүй хүн амын эзлэх хувь аймгийнхаа дунджаас дээгүүр байна. Харин Баян, Баян-Өнжүүл, Баянцагаан, Лүн, Баянхангай сумдад боловсролтой хүн амын тоо харьцангуй илүү байна.

**Зураг 6.2 Дээд боловсролтой хүн амын тоо насны бүлэг, хүйсээр 2000 он**



Дээд боловсролтой 40 хүртэл настай хүн амд дээд боловсролтой эмэгтэйчүүд давамгайлж, 40-44 насанд хүйсийн харьцаа тэнцвэртэй болж, 45-аас дээш насанд эрэгтэйчүүд илүү байгаа нь манай улсын боловсролын хөгжлийн үе шат, эрэгтэй, эмэгтэйчүүдийн боловсрол эзэмших түүхэн боломж, нөхцөлтэй холбоотой юм.

**Зураг 6.3 Долоо, түүнээс дээш насны боловсролтой хүн амын бүтэц, боловсролын түвшингээр, 2000 он**



## Бичиг үсгийн мэдлэг

Бичиг үсгийн мэдлэгийн тодорхойлолтын талаарх НҮБ-ын зөвлөмжийг 2000 оны тооллогод үндсэнд нь баримталсан юм. Аль нэг хэлээр энгийн өгүүлбэрийг уншиж, ойлгож, бичиж чаддаг хүнийг бичиг үсэг мэддэг хүн гэж үзсэн.


**Хүснэгт 6.5 Арван тав, түүнээс дээш насны хүн амын бичиг үсгийн мэдлэг, хүйс, хот, хөдөөгөөр, 2000 он**

Бичиг үсгийн мэдлэг	Хүйс				Байршил					
	Эрэгтэй		Эмэгтэй		Хот		Хөдөө		Дүн	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
15-аас дээш насны хүн ам	33151	100.0	30182	100.0	10567	100.0	52766	100.0	63333	100.0
Бичиг үсэг мэддэг	32228	97.2	29203	96.8	10344	97.9	51087	96.8	61431	97.0
Бичиг үсэг мэддэггүй	923	2.8	979	3.2	223	2.1	1679	3.2	1902	3.0

Арван тав, түүнээс дээш насны хүн амын 97.0 хувь нь бичиг үсэг мэддэг (Улсын дундаж 97.8), харин 3.0 хувь нь бичиг үсэг мэддэггүй. Бичиг үсэг мэддэггүй хүмүүсийн тоо, хүйс болон хот, хөдөөгөөр нэлээд ялгаатай. Бичиг үсэг мэддэггүй хүмүүс эмэгтэйчүүдийн дунд илүү олон байна.

Арван таваас дээш насны хүн амын 3.0 хувь нь бичиг үсэг мэддэггүй байхад энэ үзүүлэлт Батсүмбэрт 4.7 хувь, Бүрэнд 4.9 хувь, Баянцогтод 4.2 хувь, Эрдэнэд 4.7 хувь, Эрдэнэсантад 4.2 хувь байгаа нь өндөр юм.

**Зураг 6.4. Арав, түүнээс дээш насны хүн амд бичиг үсэг мэддэг хүний эзлэх хувийг аймгуудын дундажтай харьцуулсан байдал, 2000 он**



Төв аймгийн хувьд бичиг үсэг мэддэг хүн амын эзлэх хувь аймгуудын дунджаас дээгүүр байна.

### Сургуульд хамрагдалт

Аймгийн 7-29 насны нийт хүн амын 44.2 хувь нь тооллогын үед боловсрол олгох ямар нэг шатны сургуульд суралцаж байв. Дээрх үзүүлэлтийг аймгуудын дундажтай харьцуулахад 2.7 пунктээр өндөр байна. Монгол Улсын “Бага, дунд боловсролын тухай” хуулиар ерөнхий боловсролын сургуульд 8 настай хүүхдийг элсүүлэхээр заасан байдаг. Гэвч тус аймгийн 7 настай хүүхдийн 24.3 хувь нь сургуульд сурдаг байна. Суурь боловсрол эзэмших 8-15 насны хүүхдийн 87.5 хувь нь сургуульд хамрагдлаа.

#### **Хүснэгт 6.6 7-29 насны хүн амын сургуульд хамрагдалт, нас, насны бүлгээр, 2000 он**

Нас	7-29 насны суурин хүн ам		Сургуульд сурдаггүй		Сургуульд сурдаг	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Бүгд	49800	55.8	27779	55.8	22021	44.2
7	2457	75.7	1861	75.7	596	24.3
8	2563	12.4	317	12.4	2246	87.6
9	2782	6.0	167	6.0	2615	94.0
10-14	13616	11.1	1507	11.1	12109	88.9
15-19	10627	62.9	6682	62.9	3945	37.1
20-24	9219	95.9	8838	95.9	381	4.1
25-29	8536	98.5	8407	98.5	129	1.5

Найман настай хүүхдийн 87.6 хувь, 9 настай хүүхдийн 94.0 хувь нь сургуульд суралцаж байна. Үүнээс харахад Төв аймагт хүүхдүүд гол төлөв 8, 9 насандаа сургуульд ордог болох нь харагдаж байна. 10-14 насанд сургуульд суралцдаг хүүхдийн эзлэх хувь 88.9 хувь болж, өмнөх 9 насныхаас бага зэрэг буурсан бол 15-19 насанд 37.1 хувь болтлоо доошилжээ. 15-19 насны сургуульд сурдаг хүний тоо 10-14 насныхаасаа 8164-өөр цөөрч, 15-19 насны сургуульд сурдаггүй хүний тоо 10-14 насныхаас 5175-аар нэмэгджээ.



Энэ нь хүүхдүүд 8 дугаар анги төгсөөд цаашид суралцах нь багасдагтай холбоотой.

**Хүснэгт 6.7 7-29 насны нийт хүн амд сургуульд суралцаж байгаа хүний эзлэх хувь, насны бүлэг, хот, хөдөө, хүйсээр, 2000 он**

Нас	Бүгд		Хот		Хөдөө	
	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм
Бүгд	39.8	49.1	49.2	59.6	38.0	47.0
7	21.4	27.3	30.0	50.0	19.7	22.9
8	85.8	89.4	93.7	96.1	84.1	88.0
9	92.3	95.7	98.3	99.6	91.1	94.9
10-14	84.2	93.7	95.7	98.5	81.9	92.6
15-19	30.0	45.8	40.8	63.8	27.8	41.9
20-24	3.8	4.6	8.1	13.6	3.0	3.0
25-29	1.0	2.1	1.5	3.6	1.0	1.7

Хөдөөгийн 7-29 насны хүн амын сургуульд хамрагдалтын хувь, хотынхоос насны бүлэгт тус бүрд бага байна. Эмэгтэйчүүдийн сургуульд хамрагдалт эрэгтэйчүүдийнхээс 9.3 пунктээр илүү байна. Энэ үзүүлэлт хот, хөдөөгийн хүн амд ч мөн ажиглагдлаа.


Хамгийн анхаарал татсан асуудал бол ЕБС-д суралцаж байгаа хүүхдүүдийн нас ахих тутам эмэгтэйчүүдийн сургуульд хамрагдалт эрэгтэйчүүдийнхээс илүү байгаа юм. Энэ нь эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийг бодвол зөвхөн сургуульд орохдоо төдийгүй, мөн сургуульд орсныхоо дараа ч сургуулиас завсардахгүй, үргэлжлүүлэн суралцах нь илүү давуутай байгааг харуулав.

**Хүснэгт 6.8 Сургуульд суралцдаггүй 8-15 насны хүүхдийн тоо, сургуульд хамрагдалт, 2000 он**

Нас	8-15 насны хүүхэд			8-15 насны сургуульд суралцдаггүй хүүхдүүд			Сургуульд хамрагдалт		
	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм
Бүгд	21572	10931	10641	2744	1878	866	87.3	82.8	91.9
8	2563	1258	1305	317	179	138	87.6	85.8	89.4
9	2782	1421	1361	167	109	58	94.0	92.3	95.7
10	2868	1403	1465	166	105	61	94.2	92.5	95.8
11	2806	1390	1416	175	127	48	93.8	90.9	96.6
12	2731	1423	1308	278	197	81	89.8	86.2	93.8
13	2651	1363	1288	373	277	96	85.9	79.7	92.5
14	2560	1317	1243	515	378	137	79.9	71.3	89.0
15	2611	1356	1255	753	506	247	71.2	62.7	80.3

Төв аймгийн хэмжээнд 2000 оны байдлаар 8-15 насны 2744 хүүхэд сургуульд суралцаагүйн 68,4 хувь (аймгуудын дундаж 61.5%) буюу 1878 нь хөвгүүд, 31,6 (аймгуудын дундаж 38.5%) хувь буюу 866 нь охид байна. Хөвгүүдийн дунд сургууль завсардалт 2.2 дахин их байна. Сургуульд хамрагдалтын хувь 12 наснаас эхлэн буурч, бүрэн бус дунд сургуулийн боловсрол эзэмших 15 насанд 71,2 (аймгуудын дундаж 63.2%) хувь болтлоо буурчээ.

**Зураг 6.5 Сургуульд суралцдаггүй 7-29 насны хүн амын тоо, насны бүлэг, хүйсээр, 2000 он**




Сургуульд суралцдаггүй 7-29 насны хүн амын эрэгтэйчүүд нь эмэгтэйчүүдээс олон байна.

**Хүснэгт 6.9 8-15 насны хүүхдийн сургуульд хамрагдалт, сумдаар, 2000 он**

Сумд	Бүгд			Үүнээс:					
	Бүгд	Эр	Эм	Сургуульд сурдаггүй			Сургуульд хамрагдалт		
				Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм
Бүгд	21572	10931	10641	2744	1878	866	87.3	82.8	91.9
Алтанбулаг	714	374	340	146	96	50	79.6	74.3	85.3
Батсүмбэр	1392	693	699	219	136	83	84.3	80.4	88.1
Баян	501	253	248	39	24	15	92.2	90.5	94.0
Баян-Өнжүүл	411	227	184	158	105	53	61.6	53.7	71.2
Баяндэлгэр	445	228	217	75	46	29	83.1	79.8	86.6
Баянжаргалан	392	175	217	34	21	13	91.3	88.0	94.0
Баянцагаан	493	243	250	61	41	20	87.6	83.1	92.0
Баянцогт	542	273	269	61	48	13	88.7	82.4	95.2
Борнуур	940	495	445	136	98	38	85.5	80.2	91.5
Бүрэн	730	397	333	193	138	55	73.6	65.2	83.5
Дэлгэрхаан	556	287	269	168	111	57	69.8	61.3	78.8
Жаргалант	1242	637	605	113	78	35	90.9	87.8	94.2
Заамар	1432	731	701	106	75	31	92.6	89.7	95.6
Лүн	733	348	385	78	57	21	89.4	83.6	94.5
Мөнгөнморьт	526	260	266	60	44	16	88.6	83.1	94.0
Өндөрширээт	449	238	211	65	44	21	85.5	81.5	90.0
Сэргэлэн	371	204	167	123	89	34	66.8	56.4	79.6
Угтаал	842	415	427	70	42	28	91.7	89.9	93.4
Эрдэнэ	685	338	347	155	100	55	77.4	70.4	84.1
Эрдэнэсант	1291	649	642	178	127	51	86.2	80.4	92.1
Баянчандмань	780	413	367	52	36	16	93.3	91.3	95.6
Зуунмод	3433	1660	1773	136	90	46	96.0	94.6	97.4
Сүмбэр	458	251	207	46	37	9	90.0	85.3	95.7
Цээл	908	470	438	88	64	24	90.3	86.4	94.5
Архуст	459	252	207	58	47	11	87.4	81.3	94.7
Аргалант	443	225	218	56	40	16	87.4	82.2	92.7
Баянхангай	404	195	209	70	44	26	82.7	77.4	87.6

Сургууль завсардалт Баян-Өнжүүл, Дэлгэрхаан, Сэргэлэн сумдад харьцангуй их байна.

**Зураг 6.6 8-15 насны хүүхдийн сургуульд хамрагдалтын хувийг аймгуудын дундажтай харьцуулсан байдал, 2000 он**



Төв аймгийн 8-15 насны хүн амын сургуульд хамрагдалт 87.3 хувь, харин аймгуудын дундаж 81.5 хувь байгаа нь тус аймгийн хүүхдүүдийн сургуульд завсардалт бага байгааг харуулав.


## Бүлэг 7: ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИ

Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогын эдийн засгийн идэвхийн талаарх ойлголт, тодорхойлолт, 1989 оныхоос ялгаатай тул энэ бүлэгт зөвхөн 2000 оны тооллогын дүнг танилцуулах болно.

### Эдийн засгийн идэвхийн байдал

Арван тав, түүнээс дээш насны хүн амыг эдийн засгийн идэвхээр нь *ажиллах хүч* (зарим тохиолдолд эдийн засгийн идэвхитэй хүн амтай тохирдог), *эдийн засгийн идэвхигүй хүн ам* гэж 2 ангилж тодорхойлов. Ажиллах хүчинд ажил эрхэлж байгаа хүн ам болон ажилгүйчүүдийг хамруулав. Төв аймгийн 15, түүнээс дээш насны хүн амын 67.2 хувь нь ажиллах хүчинд хамаарагдаж байгаа нь улсын дунджаас 5.3 пунктээр илүү харин аймгуудын дунджаас 1.2 пунктээр доогуур байгаа юм. Энэ үзүүлэлтийг *ажиллах хүчний оролцооны түвшин* гэж нэрлэдэг. Харин 32.8 хувь нь эдийн засгийн идэвхигүй хүн амд хамаарч байна. Ажиллах хүчний 67.2 хувийн 55.6 хувь нь ажил эрхлэгчид, 11.6 хувь нь ажилгүйчүүд байгаа юм.

### Зураг 7.1 Арван тав, түүнээс дээш насны хүн амын ажиллах хүчний оролцооны түвшин, 2000 он



Аймгийн нийт хүн амын гуравны хоёроос илүү нь ажиллах хүчинд хамаарч байгаа боловч ажиллах хүчний оролцооны түвшин хүйс, хот, хөдөө жигд биш байна. Эрэгтэйчүүдийн 74.0 хувь (улс 68.6%) нь ажиллах хүчинд хамаарч байгаа нь эмэгтэйчүүдийнхээс (59.7%) бараг 15 пунктээр өндөр (Хүснэгт 7.1) байна. Гэхдээ Төв аймгийн 15, түүнээс дээш насны хүн амын ажиллах хүчний оролцооны түвшин эрэгтэй, эмэгтэйчүүдийн хувьд аль аль нь улсын түвшингээс өндөр байна.

**Хүснэгт 7.1 Хүн амын эдийн засгийн идэвхийн байдал, хот, хөдөө, хүйсээр, дүнд эзлэх хувиар, 2000 он**

Эдийн засгийн идэвхийн байдал	Хот			Хөдөө			Бүгд		
	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Ажиллах хүч	70.0	58.6	64.3	74.8	60.0	67.8	74.0	59.7	67.2
Эдийн засгийн идэвхигүй	30.0	41.4	35.7	25.2	40.0	32.2	26.0	40.3	32.8

Ажиллах хүчний оролцооны түвшин хөдөөд хотынхоос өндөр байна. Ялангуяа хөдөөгийн эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин хотынхоос 4,8 пунктээр дээгүүр байгаа нь тооллогоор мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлдэг өрхийн 15-аас дээш настай хүмүүсийг ажил эрхэлдэг гэж үзсэнтэй холбоотой юм. Эдийн засгийн идэвхигүй хүн амд багтаж байгаа эмэгтэйчүүдийн тоо хот, хөдөөд аль алинд нь эрэгтэйчүүдийнхээс харьцангуй олон байна.

Ажиллах хүчний оролцоо нь насны бүлгээр нэлээд ялгаатай байна. (Хүснэгт 7.2). Ажиллах хүчний оролцоо 15-19 насны хүн амд дөнгөж 51.0 хувь байгаагийн дотор энэ насны эмэгтэйчүүдийн 41,1 хувь нь ажиллах хүчинд хамаарч байгаа нь эрэгтэйчүүдийнхээс доогуур байна. Энэ нь 15-19 насны эрэгтэйчүүдээс эмэгтэйчүүдийн сургуульд хамрагдалт илүү байгаагаар холбоотой. Ажиллах хүчний оролцоо 25-44 насанд хамгийн өндөр (80 хувиас дээш) байгаагийн дотор эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо эмэгтэйчүүдийнхээс насны бүлэг бүрд өндөр байна. Харин 55-59 насны эрэгтэйчүүдийн ажил эрхлэлт мөн насны эмэгтэйчүүдийнхээс 2.4 дахин өндөр байгаа нь 55 нас хүрсэн эмэгтэйчүүд өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрхтэй байсантай холбоотой.

**Хүснэгт 7.2 Ажиллах хүч, эдийн засгийн идэвхигүй хүн ам, насны бүлэг, хүйсээр, 2000 он**

Насны бүлэг	Ажиллах хүч						Эдийн засгийн идэвхигүй хүн ам					
	Эрэгтэй		Эмэгтэй		Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй		Бүгд	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Бүгд	24540	74.0	18035	59.8	42575	67.2	8611	26.0	12147	40.2	20758	32.8
15-19	3449	59.1	1967	41.1	5416	51.0	2389	40.9	2822	58.9	5211	49.0
20-24	4244	84.0	3070	73.7	7314	79.3	811	16.0	1094	26.3	1905	20.7
25-34	7122	85.1	5851	76.8	12973	81.2	1246	14.9	1766	23.2	3012	18.8
35-44	5331	85.7	4713	79.7	10044	82.8	887	14.3	1201	20.3	2088	17.2
45-54	2666	83.7	1763	56.0	4429	69.9	520	16.3	1386	44.0	1906	30.1
55-59	978	69.4	349	26.4	1327	48.6	432	30.6	973	73.6	1405	51.4
60 +	750	24.4	322	10.0	1072	17.0	2326	75.6	2905	90.0	5231	83.0

\*Ажиллах хүчний оролцооны түвшин

## Ажиллах хүч


Ажиллах хүчинд ажил эрхэлж байгаа болон ажил хайж байгаа ажилгүй хүмүүсийг хамруулсныг дээр тэмдэглэсэн. Ажил эрхэлдэг хүн амд тооллогын өмнөх 7 хоногт эсвэл түүний аль нэг өдөр цалин, орлоготой ажил эрхэлсэн хүнийг хамруулсан. Тухайн хугацаанд ажил идэвхитэй хайж байсан хүмүүсийг ажилгүйчүүд гэж үзсэн. Гэхдээ тооллого 1-р сарын эхээр явагдсан учраас өвлийн улиралд түр хугацаагаар ажлаа эрхэлдэггүй улиралын чанартай ажиллагчид, өвчтэй, амралттай зэрэг шалтгааны улмаас ажил хийгээгүй ажилдаа эргэж орох хүмүүсийг ажил эрхэлдэг хүн амд оруулсан болно.

### Хүснэгт 7.3 Ажиллах хүчний тоо, хот, хөдөө, хүйсээр, 2000 он

	Хот			Хөдөө			Бүгд		
	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
Ажиллах хүч- Бүгд	3704	3093	6797	20836	14942	35778	24540	18035	42575
Ажиллагсад	2943	2489	5432	17570	12224	29794	20513	14713	35226
Ажилгүйчүүд	761	604	1365	3266	2718	5984	4027	3322	7349

Төв аймгийн нийт ажиллах хүчний 84.0 хувь (улсын дунджаар 48.7 хувь) хөдөө, 16.0 хувь (улсын дунджаар 51.3 хувь) хотод байнга оршин суугчид байна. Энэ нь тус аймгийн хот, хөдөөгийн хүн амын харьцаатай уялдаатай (Хүснэгт 2.2) байна. Ажиллах хүчинд багтаж байгаа эрэгтэйчүүдийн тоо эмэгтэйчүүдээс харьцангуй их байгаа ба энэ байдал хот, хөдөөд аль алинд нь ажиглагдаж байна.

### Зураг 7.2 Арван тав, түүнээс дээш насны хүн амын ажиллах хүчний оролцооны түвшин, насны бүлэг, хүйсээр, 2000 он



Ажил эрхэлдэг хүн амыг эрхэлдэг ажил, үйл ажиллагааны үндсэн чиглэл, ажил эрхэлтийн байдлаар нь ангилж тодорхойлов.

#### Хүснэгт 7.4 Хүн амын ажил эрхлэлтийн түвшин, хүйс, хот, хөдөөгөөр, 2000 он

Хүйс	Хот		Хөдөө		Бүгд	
	мян.хүн	хувь	мян.хүн	хувь	мян.хүн	хувь
Бүгд	5.4	51.4	29.8	56.5	35.2	55.6
Эрэгтэй	2.9	55.7	17.6	63.1	20.5	61.9
Эмэгтэй	2.5	47.1	12.2	49.1	14.7	48.7

\*15, түүнээс дээш насны хүн амд ажил эрхэлдэг хүн амын эзлэх хувь

Ажил эрхлэлтийн хүйсийн ялгаатай байдал хот, хөдөөд нэг адил ажиглагдаж, хот, хөдөөгийн аль алинд ажил эрхэлж байгаа эрэгтэйчүүдийн нийт хүн амд эзлэх хувь эмэгтэйчүүдийнхээс өндөр байна.

#### Хүснэгт 7.5 Ажил эрхэлдэг хүн ам, ажил эрхлэлтийн түвшин, насны бүлэг, хүйсээр, 2000 он

Насны бүлэг	Эрэгтэй		Эмэгтэй		Бүгд	
	мян.хүн	хувь	мян.хүн	хувь	мян.хүн	хувь
Бүгд	20513	61.9	14713	48.7	35226	55.6
15-19	2618	44.8	1282	26.8	3900	36.7
20-24	3419	67.6	2354	56.5	5773	62.6
25-34	5877	70.2	4735	62.2	10612	66.4
35-44	4529	72.8	4013	67.9	8542	70.4
45-54	2382	74.8	1664	52.8	4046	63.9
55-59	940	66.7	345	26.1	1285	47.0
60+	748	24.3	320	9.9	1068	16.9

\*15, түүнээс дээш насны хүн амд ажил эрхэлдэг хүн амын эзлэх хувь

Ажил эрхэлдэг хүн амын эзлэх хувь 20-54 насанд 60-аас дээш хувь байгаагийн дотор 35-44 насанд хамгийн өндөр байна. 15-19 насанд ажил эрхэлж байгаа хүн амын эзлэх хувийн жин бага байгаа нь ихэнх залуучууд мэргэжил боловсрол эзэмшиж сургуульд суралцаж байгаатай холбоотой. 55-аас дээш насанд тухайн насны бүлэгт ажил эрхэлж байгаа хүн амын эзлэх хувийн жин буурч байгаа нь хуулиар тэтгэвэр тогтоолгох эрхтэй болж, хүмүүс тэтгэвэрт гарч байгаагийн дээр хот суурин газарт тэдгээр хүмүүст тохирох ажлын байр хомсдолтой байгаатай холбон үзэж болох юм. Харин дээд боловсролтой 40 хүртэл настай хүмүүсийн дотор эмэгтэйчүүд давамгайлж байгаа (Зураг 6.2) боловч эдгээр насны бүлгүүдэд эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтийн түвшин эрэгтэйчүүдийнхээс нэлээд доогуур байгаа нь цаашид анхаарах асуудлын нэг юм.

Ажил эрхэлдэг нийт хүн амыг тэдний ажиллаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэлээр ангилав. Аймгийн хэмжээнд нийт ажиллагсдын 61.4 (улсын дундаж 47.1%) хувь нь хөдөө аж ахуйн салбарт ажил эрхэлдэг нь хамгийн өндөр хувийг эзлэв.

Нийт ажиллагсдын 17.2 (улсын дундаж 18.1%) хувь нь эрүүл мэнд, боловсрол, төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын үйл ажиллагааны салбарт ажиллажээ.

## Хүснэгт 7.6 Ажил эрхэлдэг хүн ам, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, хүйсээр, 2000 он

Эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбар	Эрэгтэй		Эмэгтэй		Бүгд	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Бүгд	20513	100.0	14713	100.0	35226	100.0
1 Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй	12983	63.3	8655	58.8	21638	61.4
2 Уул уурхай, олборлох үйлдвэр	949	4.6	223	1.5	1172	3.3
3 Боловсруулах үйлдвэр	1024	5.0	881	6.0	1905	5.4
4 Барилга	446	2.2	101	0.7	547	1.6
5 Цахилгаан, хий үйлдвэрлэл, ус хангамж	312	1.5	95	0.6	407	1.2
6 Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйл ажиллагаа	501	2.4	885	6.0	1386	3.9
7 Зочид буудал, зоогийн газар	118	0.6	262	1.8	380	1.1
8 Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	729	3.6	244	1.7	973	2.8
9 Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	50	0.2	74	0.5	124	0.4
10 Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн бусад үйл ажиллагаа	58	0.3	86	0.6	144	0.4
11 Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын үйл ажиллагаа	2288	11.2	761	5.2	3049	8.7
12 Боловсрол	487	2.4	1375	9.3	1862	5.3
13 Эрүүл мэнд, нийгмийн халамж	266	1.3	872	5.9	1138	3.2
14 Нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ	253	1.2	158	1.1	411	1.2
15 Бусад <sup>1</sup>	49	0.2	41	0.3	90	0.3

<sup>1</sup> Бусад гэсэн хэсэгт хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн аж ахуй, олон улсын байгууллага, гадаадад ажиллаж байгаа манай иргэд үйл ажиллагааны чиглэл нь тодорхойгүйгээс салбараар ангилах боломжгүй хүмүүс орсон.

Боловсрол, эрүүл мэнд, худалдааны салбарт ажиллагчдын дотор эмэгтэйчүүдийн эзлэх хувь өндөр байхад уул уурхай, олборлох аж үйлдвэр, тээвэр, агуулахын аж ахуйн салбарт ажиллагчдын дотор эрэгтэйчүүдийнх өндөр байна.

Ажил эрхэлж байгаа хүмүүсийн ажил эрхлэлтийн байдлыг олон улсын нийтлэг арга зүйд нийцүүлэн, бусдад гэрээгээр ажиллагч, ажил олгогч буюу хүн хөлслөн ажиллуулагч, хувиараа ажиллагч, гэр бүлийн бизнест цалин хөлсгүй ажиллагч гэж ангилав.

## Хүснэгт 7.7 Ажил эрхэлдэг хүн ам, ажил эрхлэлтийн байдал, хүйсээр, 2000 он

Хүйс	Ажил эрхлэлтийн байдал					Бүгд
	Гэрээгээр ажиллагч	Ажил олгогч	Хувиараа ажиллагч	Гэр бүлийн бизнест цалин авалгүй оролцогч	Бусад	
Бүгд	12664	219	11627	10019	697	35226
Эрэгтэй	7254	157	9488	2961	653	20513
Эмэгтэй	5410	62	2139	7058	44	14713



Ажил эрхлэлтийн хүйсийн харьцаа манай орны онцлог байдлаас шалтгаалан нэлээд ялгаатай байна. Хувиараа ажил эрхлэгчдийн дотор эрэгтэйчүүд илт давуу байгаа нь тооллогод мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлдэг өрхийн тэргүүлэгчдийг хувиараа хөдөлмөр эрхлэгч гэж авсантай холбоотой. Нөгөө талаар Төв аймагт хөдөөгийн хүн ам давамгайлж тэд мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж байгаатай холбоотой юм. Мөн гэр бүлийн бизнест цалин авалгүй оролцогчдын дийлэнх нь эмэгтэйчүүд юм.

## Ажилгүйчүүд

Ажилгүйдлийн талаарх Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Нэгдсэн Үндэсний Байгууллагын ойлголт, зөвлөмжийг 2000 оны тооллогод хэрэглэсэн юм. Тооллогын товын өмнөх долоо хоногт цалин, орлоготой ажил эрхлээгүй боловч ажил хайж байгаа хүмүүсийг ажилгүйчүүд гэж үзсэн.

Тооллогын дүнгээр Төв аймагт 7.3 мянган хүн ажилгүйчүүдэд хамаарч байгаа нь тус аймгийн ажиллах хүчний 17.3 хувийг (улсын дундаж 17.5%, аймгуудын дундаж 15.4%) эзэлж байв. Ажилгүйдлийн түвшин хүйсээр ялгаатай байгаа нь хүснэгт 7.8-аас харагдаж байна. Ажилгүйдлийн түвшин эрэгтэйчүүдийн дунд 16.4 хувь (улсын дундаж 18.2%), эмэгтэйчүүдийн дунд 18.4 хувь (улсын дундаж 16.6%) байна. Ажилгүйдлийн түвшин хот, хөдөөгөөр мөн ялгаатай байна. Хотод ажилгүйдлийн түвшин хөдөөгийнхөөс 3.4 пунктээр дээгүүр байна.

### Хүснэгт 7.8 Ажилгүйчүүдийн тоо, ажилгүйдлийн түвшин, хүйс, хот, хөдөөгөөр, 2000 он

Хүйс	Хот		Хөдөө		Бүгд	
	тоо	Ажилгүйдлийн түвшин	тоо	Ажилгүйдлийн түвшин	тоо	Ажилгүйдлийн түвшин
Бүгд	1365	20.1	5984	16.7	7349	17.3
Эрэгтэй	761	20.5	3266	15.7	4027	16.4
Эмэгтэй	604	19.5	2718	18.2	3322	18.4

Аймгийн дунджаар ажилгүйдлийн түвшин 17.3 хувь байхад Архустад 47.3 хувь, Цээлд 42.0 хувь, Батсүмбэрт 33.2 хувь байгаа нь бусдаас өндөр байгаа юм.

### Эдийн засгийн идэвхигүй хүн ам

Арван тав, түүнээс дээш настай, тооллогын өмнөх 7 хоногт цалин, орлоготой ажил эрхэлж байгаа эсвэл ажил хайж байгаагаас бусад хүн амыг эдийн засгийн идэвхигүй хүн амд хамруулж, тэднийг ажил эрхлээгүй болон ажил хайхгүй байгаа шалтгаанаар нь ангилж тодорхойлов.

Төв аймгийн арван тав, түүнээс дээш насны нийт хүн амын 32.8 хувийг эдийн засгийн идэвхигүй хүн эзлэв.

**Хүснэгт 7.9 Эдийн засгийн идэвхигүй хүн амын тоо, ажил эрхлээгүй шалтгаан, хүйсээр, 2000 он**

Ажил эрхлээгүй шалтгаан	Эрэгтэй		Эмэгтэй		Бүгд	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Бүгд	8611	100.0	12147	100.0	20818	100.0
Тохирох ажил олдохгүй	1692	19.6	1311	10.8	3003	14.5
Сургуульд сурдаг	1884	21.9	2411	19.8	4295	20.7
Тэтгэвэр, нөхөн олговорт	2544	29.5	4989	41.1	7533	36.3
Өвчтэй, тахир дутуу	759	8.8	598	4.9	1357	6.5
Гэрийн ажилтай	400	4.6	2341	19.3	2741	13.2
Бусад	1332	15.5	497	4.1	1829	8.8

Гэрийн ажилтай эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 8 дахин олон байгаа нь эмэгтэйчүүдийн уламжлалт ёс заншилтай холбоотой юм. Харин гэрийн ажилтай эрэгтэйчүүд 400 байгааг нарийвчлан судлах нь зүйтэй. Мөн өвчтэй, тахир дутуугийн группт болон бусад гэсэн шалтгаанаар ажил эрхлээгүй гэж хариулсан эрэгтэйчүүдийн тоо эмэгтэйчүүдийнхээс илүү олон байна.

Арван таваас дээш насны нийт хүн амд эдийн засгийн идэвхигүй хүн амын эзлэх хувь аймгийн дунджаар 32.8 хувь байхад Архуст, Батсүмбэр, Баянхангай, Баянчандмань, Жаргалант сумдад 40-өөс илүү хувь байгаа нь анхаарах асуудлын нэг юм.

## Бүлэг 8: ӨРХ, ОРОН СУУЦНЫ ТӨРӨЛ, НӨХЦӨЛ

Хүн ам, орон сууцны 2000 улсын тооллогоор хүн амын орон сууцны төрөл, нөхцлийг тодорхойлов.

### Өрх

Төв аймгийн өрхийн тоо 2000 онд 1989 оныхоос 1916 өрхөөр буюу 8,9 хувь өссөний дотор хотын өрх 18.3 хувь буурч, хөдөөгийнх 16.3 хувь өссөн байна.

#### Хүснэгт 8.1 Өрхийн тоо, хот, хөдөөгөөр, 1989, 2000 он

Байршил	1989		2000	
	тоо	хувь	тоо	хувь
Бүгд	21712	100.0	23638	100.0
Хот	4642	21.4	3792	16.0
Хөдөө	17070	78.6	19846	84.0

Энэ удаагийн тооллогоор олон улсын нийтлэг жишиг аргачлалын дагуу өрхийг хэлбэрээр нь ангилж тодорхойлов (холбогдох тодорхойлолтыг хүн амын тооллогод хэрэглэсэн ойлголт тодорхойлолт гэсэн хавсралтаас үзнэ үү).

#### Хүснэгт 8.2 Өрхийн тоо, өрхийн хэлбэр, хот, хөдөөгөөр, 2000 он

Байршил	Ганц бие өрх		Ам бүлээрээ		Нийлмэл өрх		Холимог өрх		Бүгд тоо
	тоо	дүнд эзлэх хувь	тоо	дүнд эзлэх хувь	тоо	дүнд эзлэх хувь	тоо	дүнд эзлэх хувь	
Бүгд	1709	100.0	15647	100.0	5883	100.0	399	100.0	23638
Хот	245	14.3	2315	14.8	1160	19.7	72	18.0	3792
Хөдөө	1464	85.7	13332	85.2	4723	80.3	327	82.0	19846

Нийт өрхийн 7.2 хувь нь ганц бие, 66.2 хувь нь ам бүлээрээ байгаа өрх, 24.9 хувь нь нийлмэл өрх, 1.7 хувь нь холимог өрх байна. Нийт өрхийн дотор ам бүлээрээ болон нийлмэл ам бүлтэй өрх дийлэнх хувийг эзэлж байгаа нь Монгол өрхийн ам бүлийн бүтцийн уламжлалт түгээмэл хэлбэрүүд хэвээр хадгалагдаж байгааг харууллаа.

Төв аймгийн өрхийн бүтцийг аймгуудын дундажтай харьцуулахад ганц бие өрх ойролцоо түвшинд, ам бүлээрээ байгаа өрх нэг пунктээр доогуур, нийлмэл ам бүлтэй өрх 2.5 пунктээр дээгүүр, харин холимог өрх 0.4 пунктээр доогуур байна.

Нийт өрхөд 1-4 хүнтэй өрх 54,0 хувийг эзэлж байгаа нь аймгуудын дунджаас 5 пунктээр бага, 5-6 хүнтэй өрх 28,3 хувь байгаа нь аймгуудын дунджаас 1 пунктээр бага, 7 ба түүнээс дээш ам бүлтэй өрх 9,3 хувийг эзэлж байгаа нь аймгуудын дунджаас нэг пунктээр бага байна. Аймгийн хэмжээний нэг өрхөд дунджаар 4,1 хүн ногдлоо.

Нэг өрхөд ногдох хүний тоогоор Угтаал сум хамгийн их буюу аймгийн дунджаас 0,4 пунктээр их, Баяндэлгэр сум хамгийн бага буюу аймгийн дунджаас 0,3 пунктээр бага гарлаа. Ганц бие өрх Зуунмод хотод 225, Батсүмбэрт 122, Эрдэнэсантад 91, Эрдэнэд 89, Жаргалантад 88 тус тус ногдов.

### Хүснэгт 8.3 Өрхийн тоо, өрхөд тоологдсон хүний тоо, нэг өрхөд ногдох хүний тоо, сумдаар, 2000 он

Сумд	Бүгд	Өрхөд тоологдсон хүн				Нэг өрхөд ногдох хүний тоо
		1	2-4	5-7	8+	
Өрх бүгд	23638	1709	13044	7897	988	4.1
Алтанбулаг	877	48	491	301	37	4.1
Батсүмбэр	1593	122	886	526	59	4.0
Баян	605	50	345	182	28	4.0
Баян-Өнжүүл	608	20	371	201	16	4.1
Баяндэлгэр	547	65	304	164	14	3.8
Баянжаргалан	429	24	236	144	25	4.2
Баянцагаан	676	58	369	216	33	4.0
Баянцогт	620	62	339	201	18	3.9
Борнуур	1026	69	562	356	39	4.1
Бүрэн	850	50	471	298	31	4.1
Дэлгэрхаан	619	68	350	162	39	4.0
Жаргалант	1343	88	751	448	56	4.1
Заамар	1429	73	784	515	57	4.2
Лүн	822	75	461	253	33	4.0
Мөнгөнморьт	618	73	333	187	25	3.9
Өндөрширээт	565	37	346	164	18	3.9
Сэргэлэн	522	54	307	144	17	3.8
Угтаал	782	30	380	333	39	4.5
Эрдэнэ	801	89	427	248	37	3.9
Эрдэнэсант	1314	91	669	501	53	4.2
Баянчандмань	793	66	428	268	31	4.0
Зуунмод	3471	225	1966	1120	160	4.1
Сүмбэр	478	17	277	172	12	4.1
Цээл	862	61	442	310	49	4.3
Архуст	505	38	283	168	16	4.0
Аргалант	483	30	265	166	22	4.1
Баянхангай	400	26	201	149	24	4.3

### Орон сууцны төрөл, нөхцөл


Төв аймгийн нийт өрхийн 35 хувь нь байшинд, 65 хувь нь гэрт амьдардаг бөгөөд хотын өрхийн 63.2 хувь байшинд, хөдөөгийн өрхийн 70.5 хувь нь гэрт амьдардаг ажээ.

### Хүснэгт 8.4 Өрхийн сууцны төрөл, хот, хөдөөгөөр, 2000 он

Сууцны төрөл	Хот		Хөдөө		Бүгд	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Бүгд	3792	100.0	19846	100.0	23638	100.0
Байшин	2395	63.2	5858	29.5	8253	34.9
Гэр	1397	36.8	13988	70.5	15385	65.1

Төв аймгийн байшинд суудаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь аймгуудын дунджаас 3.3 пунктээр илүү, харин гэрт суудаг өрхийнх 3.3 пунктээр доогуур байна (Зураг 8.2).

### Зураг 8.1 Өрхийн сууцны төрөл, 2000 он



### Хүснэгт 8.5 Өрхийн сууцны эзэмшил, хот, хөдөөгөөр, 2000 он

Сууцны эзэмшил	Хот		Хөдөө		Бүгд	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Бүгд	3792	100.0	19846	100.0	23638	100.0
Сууц эзэмшигч өрх	3529	93.1	19483	98.2	23012	97.4
Хамтран суугч өрх	263	6.9	363	1.8	626	2.6

Хамтран суугч өрх гэдэгт айлын сууцанд амьдарч байгаа өрхийг хамруулж байгаа бөгөөд энэ нь өөрийн эзэмшлийн сууцгүй өрхүүд юм.

### Хүснэгт 8.6 Өрхийн сууцны төрөл, сумдаар, гэрт амьдардаг өрх ханын тоогоор, 2000 он

Сумд	Бүх өрх	Сууцны төрөл, хувиар		Гэрт суудаг өрх ханын тоогоор, хувиар			
		Байшинд	Гэрт	5 хүртэл	5	6	8+
Төв аймаг	23638	34.9	65.1	22.7	74.7	1.8	0.8
Алтанбулаг	877	16.1	83.9	24.1	74.7	0.8	0.4
Батсүмбэр	1593	54.4	45.6	21.1	75.3	2.5	1.1
Баян	605	31.9	68.1	18.2	81.1	0.0	0.7
Баян-Өнжүүл	608	1.0	99.0	20.1	79.6	0.3	0.0
Баяндэлгэр	547	18.6	81.4	36.0	63.8	0.2	0.0
Баянжаргалан	429	7.7	92.3	29.0	70.2	0.8	0.0
Баянцагаан	676	5.3	94.7	19.7	78.8	0.9	0.6
Баянцогт	620	38.5	61.5	28.6	68.8	1.3	1.3
Борнуур	1026	44.2	55.8	19.2	75.6	4.3	0.9
Бүрэн	850	2.0	98.0	22.0	78.0	0.0	0.0
Дэлгэрхаан	619	1.9	98.1	4.9	95.1	0.0	0.0
Жаргалант	1343	49.6	50.4	15.8	75.5	4.6	4.1
Заамар	1429	42.2	57.8	26.3	69.1	3.1	1.5
Лүн	822	20.0	80.0	19.8	74.9	2.0	3.3
Мөнгөнморьт	618	26.2	73.8	35.1	63.8	1.1	0.0
Өндөрширээт	565	7.3	92.7	26.9	72.1	0.4	0.6
Сэргэлэн	522	16.3	83.7	27.7	70.0	1.6	0.7
Угтаал	782	49.1	50.9	17.9	78.1	3.0	1.0
Эрдэнэ	801	23.3	76.7	30.3	66.5	2.4	0.8
Эрдэнэсант	1314	12.1	87.9	17.4	81.9	0.6	0.1
Баянчандмань	793	58.6	41.4	23.2	74.1	1.8	0.9
Зуунмод	3471	62.7	37.3	28.6	68.9	2.0	0.5
Сүмбэр	478	51.5	48.5	13.8	80.6	4.3	1.3
Цээл	862	47.7	52.3	16.0	77.4	5.5	1.1
Архуст	505	34.5	65.5	40.5	57.7	1.5	0.3
Аргалант	483	27.3	72.7	15.4	80.1	4.5	0.0
Баянхангай	400	24.8	75.2	17.3	78.1	3.6	1.0

6 болон 8-аас дээш ханатай гэрт амьдарч байгаа өрх ерөнхийдөө ихэнх сумдад 2 хүрэхгүй хувийг эзэлж байгаа бөгөөд Борнуур, Жаргалант, Сүмбэр, Цээл, Аргалант сумдад 6-аас дээш ханатай гэрт амьдарч байгаа өрхийн эзлэх хувь бусад сумдаасаа арай өндөр гарлаа.

Батсүмбэр, Борнуур, Жаргалант, Заамар, Баянчандмань, Цээл сумдын 42.2-59.6 хувь нь байшинд амьдарч байгаа нь бусдаас өндөр байна.


Нийт өрхийн 93.2 хувь нь хувийн, 6.4 хувь нь төрийн, 0.4 хувь нь холимог өмчийн сууцанд амьдарч байна. Байшинд суудаг нийт өрхийн 81.5 хувь нь байраа өөрсдөө өмчилдөг, гэрт суугаа өрхийн 99.5 хувь нь хувийн гэртээ амьдардаг ажээ.

### Хүснэгт 8.7 Өрхийн тоо, цахилгаан болон телефон утасны хангамж, хот, хөдөөгөөр, 2000 он

Үзүүлэлт	Хот		Хөдөө		Бүгд	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Цахилгаан гэрэлтэй	3619	95.4	11393	57.4	15012	63.5
Цахилгаан гэрэлгүй	173	4.6	8453	42.6	8626	36.5
Телефон утастай	866	22.8	374	1.9	1240	5.2
Телефон утасгүй	2926	77.2	19472	98.1	22398	94.8

Төв аймагт телефон утасны хэрэглээ ерөнхийдөө бага байгаагийн дотор хотын өрхийн 23 хувь нь, хөдөөгийн өрхийн дөнгөж 2 хувь нь телефон утас хэрэглэв. Цахилгаан гэрлийн хангамж хотын өрхийг бодвол хөдөөд арай бага байна.

**Зураг 8.2 Өрхийн цахилгаан болон телефон утасны хангамжийг аймгуудын дундажтай харьцуулсан байдал, 2000 он**



### Байшинд амьдардаг өрх

Төв аймгийн байшинд амьдардаг нийт өрхийн 29.0 хувь нь хотод, 71.0 хувь нь хөдөөд суурьшдаг. Байшинд амьдардаг нийт өрхийн 92.0 хувь нь сууцны зориулалтаар баригдсан сууцны тусдаа байшин болон нийтийн сууцны байшин доторх сууцанд, 5.1 хувь нь нийтийн байранд, харин 3.0 хувь нь сууцны бус болон бусад зориулалтаар баригдсан байшинд амьдардаг байна.

### Хүснэгт 8.8 Байшинд амьдардаг өрх, сууцны зориулалт, хот, хөдөөгөөр, 2000 он

Сууцны зориулалт	Байршил				Бүгд	
	Хот		Хөдөө			
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Бүгд	2395	100.0	5858	100.0	8253	100.0
Байшин						
Сууцны тусдаа байшин	1120	46.8	4698	80.2	5818	70.5
Нийтийн сууцны байшин/д сууц	1093	45.6	672	11.5	1765	21.4
Нийтийн байр	72	3.0	351	6.0	423	5.1
Сууцны бус болон бусад байр	110	4.6	137	2.3	247	3.0

Улсын дунджаар сууцны тусдаа байшинд амьдардаг өрх байшинд суудаг нийт өрхийн 25 хувийг эзэлж байхад Төв аймагт 71 хувь нь сууцны тусдаа байшинд амьдарч байгаа нь 2.8 дахин олон байна.

**Хүснэгт 8.9 Байшинд амьдардаг өрх, өрхөд тоологдсон хүний тоо, сууцны талбайгаар, 2000 он**

Өрхөд тоологдсон хүн	20-иос бага		21-40		40-өөс дээш		Бүгд	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Бүгд	3322	40.3	3865	46.8	1066	12.9	8253	100.0
1-2	716	56.0	459	35.9	103	8.1	1278	100.0
3-4	1501	41.0	1689	46.2	467	12.8	3657	100.0
5-6	829	32.7	1317	52.0	389	15.3	2535	100.0
7+	276	35.2	400	51.1	107	13.7	783	100.0

Байшинд амьдардаг нийт өрхийн 40 хувь нь 20-иос бага, 47 хувь нь 21-40, 13 хувь нь 40-өөс дээш кв.м сууцны талбайд амьдардаг байна. Энэ үзүүлэлтийг улсын дундажтай (29%) харьцуулж үзвэл 20-иос бага кв.м талбайд амьдардаг өрхийн хувь Төв аймагт харьцангуй өндөр байна.


**Хүснэгт 8.10 Байшинд амьдардаг өрхийн халаалт, усан хангамж, хот, хөдөөгөөр, 2000 он**

Үзүүлэлт	Хот		Хөдөө		Бүгд	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Бүгд	2395	100.0	5858	100.0	8253	100.0
Халаалт						
Төвлөрсөн	263	11.0	-	-	263	3.2
Төвлөрсөн бус	1262	52.7	894	15.3	2156	26.1
Бусад	870	36.3	4964	84.7	5834	70.7
Нийт	2395	100.0	5858	100.0	8253	100.0
Усан хангамж						
Халуун, хүйтэн устай	36	1.5	-	-	36	0.4
Зөвхөн хүйтэн устай	1040	43.4	158	2.7	1198	14.5
Зөөврийн	1319	55.1	5700	97.3	7019	85.1
гүний	1120	46.8	4546	77.6	5666	68.6
уурхайн	3	0.1	165	2.8	168	2.0
бусад	196	8.2	989	16.9	1185	14.4
Нийт	2395	100.0	5858	100.0	8253	100.0

Байшинд амьдардаг нийт өрхийн дөнгөж 3.2 хувь нь төвлөрсөн халаалттай, 0.4 хувь нь халуун, хүйтэн устай байгаагийн дотор хөдөөд төвлөрсөн халаалттай, халуун, хүйтэн устай байшинд амьдардаг өрх байхгүй байна. Мөн байшинд амьдардаг нийт өрхийн 70.7 хувь нь ердийн халааттай, 85 хувь нь зөөврийн ус хэрэглэж байгаа нь орон нутагт иргэд ихэвчлэн өөрсдийн хүч хөрөнгөөр барьсан сууцны тусдаа байшинд амьдарч байгаатай холбоотой. Улсын дунджаар хотын өрхийн 55 хувь нь төвлөрсөн халаалттай, 49 хувь нь халуун, хүйтэн устай сууцанд амьдардаг байна.



**Зураг 8.3 Байшинд амьдардаг өрхийн усан хангамжийг аймгуудын дундажтай харьцуулсан байдал, 2000 он**



Аймгуудын дунджаар байшинд амьдардаг өрхийн 11 хувь нь халуун, хүйтэн устай байхад Төв аймгийн өрхийн дөнгөж 0.4 хувь нь халуун, хүйтэн ус хэрэглэж байна. Энэ нь тус аймагт халуун, хүйтэн устай нийтийн сууц цөөн, сууцны тусдаа байшин зонхилж байгаатай холбоотой юм.

*Хүснэгт 8.11 Байшинд амьдардаг өрхийн сууцны нөхцөл, хот, хөдөөгөөр, 2000 он*

Үзүүлэлт	Хот		Хөдөө		Бүгд	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Бүгд	2395	100.0	5858	100.0	8253	100.0
Бие засах газар						
Сууц дотроо	1106	46.2	-	-	1106	13.4
Сууцны гадна	1289	53.8	5858	100.0	7147	86.6
Гал тогооны өрөө						
Өрөөтэй	1989	83.1	5044	86.1	7033	85.2
Өрөөгүй	396	16.5	778	13.3	1174	14.2
Нийтийн	10	0.4	36	0.6	46	0.6
Онгоц, шүршүүрийн өрөө						
Өрөөтэй	849	35.4	-	-	849	10.3
Өрөөгүй	1542	64.4	5831	99.5	7373	89.3
Нийтийн	4	0.2	27	0.5	31	0.4


Байшинд амьдардаг нийт өрхийн 86.6 хувь, үүний дотор хөдөөгийн бүх өрх, хотын өрхийн 53.8 хувь нь сууцны гадна бие засах газартай байна. Энэ нь байшинд амьдардаг өрхийн дийлэнх нь буюу 71 хувь нь сууцны тусдаа байшинд амьдардагтай холбоотой.

**Хүснэгт 8.12 Байшинд амьдардаг өрхийн хог зайлуулалт, хот, хөдөөгөөр, 2000 он**

Хог зайлуулалт	Хот		Хөдөө		Бүгд	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Төвлөрсөн цэгт	1523	63.6	2439	41.7	3962	48.0
Дангаараа	631	26.3	2655	45.3	3286	39.8
Тодорхой цэг байхгүй	241	10.1	764	13.0	1005	12.2

Байшинд амьдардаг хөдөөгийн өрхийн 45 хувь нь дангаараа, хотын өрхийн 64 хувь нь төвлөрсөн цэгт хогоо хаядаг. Хог зайлуулах тодорхой цэг байхгүй өрхийн тоо хотыг бодвол хөдөөд илүү олон байна.

**Зураг 8.4 Байшинд амьдардаг өрхийн хог зайлуулалтыг аймгуудын дундажтай харьцуулсан байдал, 2000 он**



Төв аймгийн байшинд амьдардаг нийт өрхөөс төвлөрсөн цэгт хогоо хаядаг өрхийн хувийн жин аймгуудын дунджаас (41.2%) өндөр байна.

**Хүснэгт 8.13 Байшинд амьдардаг өрхийн цахилгаан болон телефон утасны хангамж, 2000 он**

Үзүүлэлт	Хот		Хөдөө		Бүгд	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Цахилгаан гэрэлтэй	2372	99.0	5661	96.6	8033	97.3
Цахилгаан гэрэлгүй	23	1.0	197	3.4	220	2.7
Телефон утастай	736	30.7	273	4.7	1009	12.2
Телефон утасгүй	1659	69.3	5585	95.3	7244	87.8

Төв аймгийн нийт өрхийн 2.7 хувь нь цахилгаан гэрэлгүй байгаа нь аймгуудын дунджаас 8.1 пунктээр доогуур байгаа нь тус аймгийн ихэнх сумд төвийн эрчим хүчний системд холбогдсонтой холбоотой.

## Гэрт амьдардаг өрх

Төв аймгийн нийт өрхийн 65 хувь нь гэрт амьдарч байгаагийн дотор 90.9 хувь нь хөдөөд, 9.1 хувь нь хотод бүртгэгдлээ.

### Хүснэгт 8.14 Гэрт амьдардаг өрх, өрхөд тоологдсон хүний тоо, гэрийн ханын тоогоор, 2000 он

Өрхөд тоологдсон хүн	Ханын тоо								Бүгд	
	5 хүртэл		5		6		8+			
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Бүгд	3484	22.7	11491	74.7	283	1.8	127	0.8	15385	100.0
1-2	1334	39.6	1982	58.9	41	1.2	10	0.3	3367	100.0
3-4	1362	21.1	4921	76.3	115	1.8	53	0.8	6451	100.0
5-6	623	15.0	3382	81.6	100	2.4	42	1.0	4147	100.0
7+	165	11.6	1206	84.9	27	1.9	22	1.6	1420	100.0

Төв аймгийн гэрт амьдардаг нийт өрхийн 74.7 хувь нь 5 ханатай гэрт амьдардагаас үзэхэд 5 ханатай гэр монголчуудын түгээмэл сууц гэдгийг харууллаа.

### Хүснэгт 8.15 Гэрт амьдардаг өрх, ахуйн нөхцөл, байршлаар, 2000 он

Өрхийн ахуйн нөхцөл	Хот		Хөдөө		Бүгд	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Хог зайлуулах цэгтэй	1060	75.9	9218	65.9	10278	66.8
Бие засах цэгтэй	1296	92.8	9413	67.3	10709	69.6
Бохир усны зориулалтын цэгтэй	1087	77.8	4736	33.9	5823	37.8

Хотын өрхийн 78 хувь, хөдөөгийн өрхийн 34 хувь нь бохир усны зориулалтын цэгтэй байгаа нь хөдөөд бохир усны цэгийг нэлээд ховор ашиггладагийг харууллаа.


**Хүснэгт 8.16 Гэрт амьдардаг өрхийн эзлэх хувь, сумдаар, ахуйн нөхцлөөр, 2000 он**

Сумд	Бүх өрх	Хог зайлуулах цэгтэй	Бие засах цэгтэй	Бохир усны зориулалтын цэгтэй
Төв аймаг	15385	66.8	69.6	37.8
Алтанбулаг	736	63.6	66.7	29.2
Батсүмбэр	726	66.0	93.4	38.0
Баян	412	65.3	54.6	32.8
Баян-Өнжүүл	602	49.3	43.5	29.9
Баяндэлгэр	445	74.2	75.5	41.3
Баянжаргалан	396	90.2	68.2	22.5
Баянцагаан	640	78.4	73.8	36.3
Баянцогт	381	54.6	57.5	30.2
Борнуур	573	64.4	89.4	53.1
Бүрэн	833	58.5	57.9	37.9
Дэлгэрхаан	607	95.6	61.3	42.5
Жаргалант	677	54.1	85.5	50.1
Заамар	826	77.8	74.9	34.5
Лүн	658	53.8	37.8	16.4
Мөнгөнморьт	456	88.4	96.3	42.3
Өндөрширээт	524	70.0	45.2	36.1
Сэргэлэн	437	51.9	55.4	28.4
Угтаал	398	53.3	52.0	33.2
Эрдэнэ	614	60.9	75.6	19.5
Эрдэнэсант	1155	52.9	50.6	25.5
Баянчандмань	328	72.0	80.5	36.9
Зуунмод	1295	75.4	92.4	77.9
Сүмбэр	232	94.8	97.0	47.4
Цээл	451	72.7	88.2	31.3
Архуст	331	73.7	74.9	40.2
Аргалант	351	63.2	76.6	39.6
Баянхангай	301	49.2	56.1	27.2

Хог зайлуулах цэгтэй өрх аймгийн дунджаар гэрт амьдардаг бүх өрхийн 66.8 хувийг эзэлж, олонх сумдад энэ үзүүлэлт 60-аас дээш хувьтай байхад Бүрэн, Жаргалант, Сэргэлэн, Эрдэнэсант, Баянхангай сумдад дөнгөж 50 орчим хувьтай байгаа нь бусад сумдаас нэлээд доогуур байна.

Мөн бие засах зориулалтын цэгтэй өрх аймгийн дунджаар 69.6 хувь байхад Баян-Өнжүүл, Лүн, Өндөрширээт сум дөнгөж 37.8-43.5 хувьтай байгаа нь анхаарах асуудлын нэг боллоо. Бохир усны цэг ашиглах нь аймгийн хэмжээнд хангалтгүй (Аймгуудын дундаж 49 хувь), гэрт суудаг нийт өрхийн дөнгөж 37.8 хувь нь бохир усны зориулалтын цэгтэй байна. Лүн, Эрдэнэ, Баянжаргалан, Баянхангай суманд энэ үзүүлэлт дөнгөж 16.4-27.2 хувьтай байна.

**Зураг 8.5 Гэрт амьдардаг өрхийн ахуйн нөхцөлийг аймгуудын дундажтай харьцуулсан байдал, 2000 он**



Бие засах болон бохир усны зориулалтын цэгтэй гэрт амьдардаг хотын өрхийн эзлэх хувь аймгуудын дунджаас дээгүүр, харин хөдөө өрхийнх аймгуудын дунджаас бүхэлдээ доогуур юм.

**Хүснэгт 8.17 Гэрт амьдардаг өрхийн усан хангамж, хот, хөдөөгөөр, 2000 он**

Усан хангамж	Хот		Хөдөө		Бүгд	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Бүгд	1397	100.0	13988	100.0	15385	100.0
Гүний худаг	1172	83.9	5299	37.9	6471	42.1
Уурхайн худаг	7	0.5	2355	16.8	2362	15.3
Гол, мөрөн	110	7.9	4564	32.6	4674	30.4
Нуур, цөөрөм	-	0.0	12	0.1	12	0.1
Бусад	108	7.7	1758	12.6	1866	12.1

Төв аймгийн гэрт амьдардаг хотын өрхийн ихэнх хувь нь (84%) гүний худгаас хэрэглэнийхээ усыг авдаг бол бусад эх үүсвэрээс усныхаа хэрэглээг хангаж байгаа өрх хөдөөд хотыг бодвол илүү өндөр хувьтай эзлэв.

**Хүснэгт 8.18 Гэрт амьдардаг өрхийн цахилгаан болон телефон утасны хангамж, 2000 он**

Үзүүлэлт	Хот		Хөдөө		Бүгд	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Цахилгаан гэрэлтэй	1247	89.3	5732	41.0	6979	45.4
Цахилгаан гэрэлгүй	150	10.7	8256	59.0	8406	54.6
Телефон утастай	130	9.3	101	0.7	231	1.5
Телефон утасгүй	1267	90.7	13887	99.3	15154	98.5

Төв аймгийн гэрт амьдардаг өрхийн 45.4 хувь нь цахилгаан гэрэлтэй, 1.5 хувь нь телефон утастай, харин хотын гэрт амьдардаг өрхийн 89.3 хувь нь цахилгаан гэрэлтэй байхад хөдөөгийнх 41 хувьтай, хотын өрхийн 9.3 хувь нь телефон утастай байхад энэ үзүүлэлт хөдөөгийнх дөнгөж 0.7 хувьтай гарлаа.

## ХАВСРАЛТ 1. Тооллогод хэрэглэсэн ойлголт, тодорхойлолт, 2000 он

Ойлголт	Тодорхойлолт	Насны хязгаар
<b>Монгол Улсад байнга оршин суудаг хүний тоо</b>	Тооллого явагдах үед Монгол Улсад байнга оршин суудаг хүн ам, өөрөөр хэлбэл байнга оршин суугч болон түр эзгүй хүний нийлбэр юм. (энд гадаадад зургаагаас дээш сараар амьдарч байгаа зарим хүмүүсийг түр эзгүй гэж оруулсан)	Бүх насны
<b>Өрх</b>	Нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын бусад хэрэгцээгээ хамтран хангадаг нэг буюу хэсэг бүлэг хүмүүсийг өрх гэнэ. Өрхийн гишүүд нь хоорондоо хамааралтай эсвэл хамааралгүй байж болно.	Бүх насны
Ам бүлээрээ байгаа өрх	Ам бүлээрээ байгаа өрх дангаараа амьдрахыг хэлнэ. Өөрөөр хэлбэл, эхнэр, нөхөр хүүхдийн (хүүхдүүдийн) хамт, мөн эцэг эсвэл эх нь хүүхдийн (хүүхдүүдийн) хамт өрх үүсгэн амьдрахыг хэлнэ.	-
<b>Нийлмэл өрх</b>	Нийлмэл өрхөд дараахь бүтэцтэй өрх хамрагдана. Үүнд: (а) нэг ам бүл бусад хамаатан садантайгаа хамт өрх үүсгэн амьдарч байж болно. Жишээлбэл, эцэг нь хүүхдүүдтэйгээ, бусад хамаатан садантайгаа; гэр бүл хосууд хамаатан садантайгаа амьдарч байж болно. (б) хоёр, түүнээс дээш, хоорондоо хамааралтай ам бүл дангаараа хамтран өрх үүсгэн амьдарч байж болно. Жишээлбэл, хоёр гэр бүл хос хүүхдүүдтэйгээ, бусад хамаатан садангүйгээр амьдарч байж болно. (в) хоёр, түүнээс дээш, хоорондоо хамааралтай ам бүл, аль нэгэнтэй нь хамааралтай хүнтэй хамт өрх үүсгэн амьдарч байж болно. Жишээлбэл, хоёр, түүнээс дээш гэр бүл хос нэг хамаатангийн хүнтэйгээ хамт амьдарч байж болно. (г) хоёр, түүнээс дээш хоорондоо хамааралтай боловч нэг ам бүлийн биш хүмүүс өрх үүсгэн амьдарч байж болно.	-
<b>Холимог өрх</b>	Холимог өрхөд дараахь бүтэцтэй өрх хамрагдана. Үүнд: (а) нэг ам бүл бусад хамаатан садан эсвэл хамааралгүй хүмүүстэй хамт өрх үүсгэн амьдарч байж болно. Жишээлбэл, эх нь хүүхдүүдтэйгээ, хамаатан садантайгаа болон хамааралгүй хүмүүстэй хамт өрх үүсгэн амьдарч байж болно. (б) нэг ам бүл, хамааралгүй хүмүүстэй хамт өрх үүсгэн амьдарч байж болно. Жишээлбэл, эцэг нь хүүхдүүдтэйгээ мөн хамаатангийн биш нэг хүнтэй өрх үүсгэн амьдарч байж болно. (в) хоёр, түүнээс дээш, хоорондоо хамааралтай ам бүл, аль нэгнийх нь хамаатан садан, хамааралгүй хүмүүстэй хамт өрх үүсгэн амьдарч байж болно. (г) хоёр, түүнээс дээш, хоорондоо хамааралтай ам бүл эдгээр ам бүлийн алинд ч хамааралгүй хүмүүстэй хамт өрх үүсгэн амьдарч байж болно. (д) хоёр, түүнээс дээш, хоорондоо хамааралгүй ам бүл бусад хүмүүстэй эсвэл хүмүүсгүйгээр амьдарч байж болно. (е) хоорондоо хамааралтай боловч ам бүлийн биш хоёр, түүнээс олон	-

	хүмүүс бусад хамааралгүй хүмүүстэй өрх үүсгэн амьдарч байж болно. (ё) хоорондоо хамааралгүй хүмүүс өрх үүсгэн амьдарч байж болно.	
<b>Нийтийн байранд тоологдсон хүн ам</b>	Хүн амын тооллогын үед өрхөд тоологдоогүй цэрэг, хоригдол, цагдан хоригдогсод, албадан саатуулагсад, урьдчилан хорих байранд хоригдогсод, эмнэлэг, сургуулийн дотуур байранд амьдарч байгаа хүмүүс	Бүх насны
<b>Хотын хүн ам, өрх</b>	<b>Нийслэл</b> - Улаанбаатар хотын 9 дүүрэгт оршин суугаа бүх хүн ам, өрх <b>Аймгийн төв</b> - 21 аймгийн төвийн сумдад оршин суугаа бүх хүн ам, өрх Тосгон - <b>Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогод зориулж ҮСГ-ын газраас гаргасан тосгоны жагсаалтад бичигдсэн суурин газарт оршин суугаа бүх хүн ам, өрх</b>	Бүх насны
<b>Тосгон</b>	<i>Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай Монгол Улсын хуульд зааснаар 500-15000 оршин суугчтай, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, аялал жуулчлал, амралт, сувилал, тээвэр, худалдаа зэрэг салбарын аль нэг нь хөгжсөн, өөрийн удирдлага бүхий суурин газрыг тосгон гэнэ.</i>	-
<b>Хөдөөгийн хүн ам, өрх</b>	<b>Сумын төв</b> - Аймгийн төв, тосгонд ороогүй бусад сумын төвд оршин суугаа бүх хүн ам, өрх Хөдөө - <b>Хөдөө эсвэл тосгоны жагсаалтанд ороогүй хөдөөгийн жижиг суурин газарт оршин суугаа бүх хүн ам, өрх</b>	-
<b>Өрхийн тэргүүлэгч</b>	Өрхийн бусад гишүүд өрхийн тэргүүн гэж өргөмжилсөн хүн.	16, түүнээс дээш настай
<b>Нас</b>	Төрсөн он, сар, өдөр, тооллогын он, сар, өдрийн хоорондох бүтэн жилээр илэрхийлэгдэх зай	Бүх насны
<b>Харъяалал</b>	Тухайн хүний тооллого явагдах үеийн хууль ёсны харъяалагдах улс	Бүх насны
<b>Яс үндэс</b>	Тухайн хүний тооллого явагдах үеийн хамаарагддаг гэж хэлж байгаа яс үндэс (Зөвхөн Монгол Улсын харъяат хүнээс асуусан.)	Бүх насны
<b>Төрсөн газар</b>	Монголд төрсөн бол төрсөн аймаг, нийслэлийн нэр, гадаадад төрсөн бол төрсөн улсын нэр	Бүх насны
<b>Байнга оршин сууж байгаа хугацаа</b>	<i>Тухайн хүний байнга оршин суудаг аймаг, нийслэлдээ тасралтгүй амьдарсан бүтэн жилийн тоо</i>	Бүх насны
<b>Өмнө нь байнга оршин сууж байсан газар</b>	Тооллогын үед байнга оршин суудаг газартаа хамгийн сүүлд шилжин ирэхээс өмнө байнга оршин сууж байсан аймаг, нийслэл, гадаадад байсан бол улсын нэр	Бүх насны
<b>1995 оны 1-р сарын 1-нд байнга оршин сууж байсан газар</b>	1995 оны 1-р сарын 1-нд байнга оршин сууж байсан аймаг, нийслэл, гадаадад байсан бол улсын нэр.	5 ба түүнээс дээш
<b>Гэрлэлтийн байдал</b>	Гэр бүлийн тухай Монгол Улсын хууль болон уламжлалт ёсны дагуу тухайн хүний тооллогын үе дэх гэрлэлтийн байдал	15 ба түүнээс дээш

<b>Боловсролын түвшин</b>	Монгол Улсын боловсролын тогтолцоо, эсвэл түүнтэй адилтгах сургууль дүүргэсэн боловсролын хамгийн дээд түвшин	7 ба түүнээс дээш
<b>Одоо суралцаж байгаа хүн ам</b>	Боловсрол олгох ямар нэг шатны сургуульд үнэмлэх авах болон мэргэжил эзэмшихээр суралцаж байгаа хүмүүс	7-29 насны
<b>Бичиг үсгийн мэдлэг</b>	Аль нэгэн хэлээр энгийн богино өгүүлбэрийг ойлгож, унших, бичих чадвар	7 ба түүнээс дээш
<b>Ажил эрхэлдэг хүн ам</b>	Сүүлийн 7 хоногт ядаж нэг өдөр ажил эрхэлсэн хүмүүс	15 ба түүнээс дээш
<b>Ажилгүйчүүд</b>	Сүүлийн 7 хоногт ажил хийгээгүй, тооллогын үед ажил хайж байгаа болон тохирох ажил олдохгүй байгаа хүмүүс	15 ба түүнээс дээш
<b>Тохирох ажил олдохгүй байгаа хүмүүс (итгэл алдарсан ажилчид)</b>	Урд нь ажил идэвхтэй хайж байгаад тохирох ажил олдохгүй итгэл алдарсны улмаас тооллогын өмнөх сүүлийн 7 хоногт ажил идэвхтэй хайгаагүй, өөрөө тохирох ажил олдохгүй гэж үзэж байгаа хүмүүс	15 ба түүнээс дээш
<b>Эдийн засгийн идэвхитэй хүн ам</b>	Тооллогын үед ажил эрхэлж байгаа хүн ам болон ажилгүйчүүд	15 ба түүнээс дээш
<b>Эдийн засгийн идэвхигүй хүн ам</b>	Эдийн засгийн идэвхгүй хүн амд тооллогын өмнөх 7 хоногт дараахь шалтгааны улмаас ажил эрхлээгүй хүн ам хамрагдана. <ul style="list-style-type: none"> <li>• Сургуульд сурдаг</li> <li>• Тэтгэвэр, нөхөн олговорт</li> <li>• Өвчтэй, тахир дутуугийн группт</li> <li>• Гэрийн ажилтай</li> <li>• Бусад</li> </ul>	15 ба түүнээс дээш
<b>Сууц</b>	Тооллогын үед айл, өрх амьдарч байсан, бүтцийн хувьд тусдаа, биеэ даасан орон байр (амьдрах зориулалтгүй байж болно).	-
<b>Байшин</b>	Бүтцийн хувьд нэг өрх амьдрах зориулалттай, нэг болон хэд хэдэн өрөөтэй сууц. Байшинд тусдаа байшин, нийтийн сууцны байшин, оюутан бусад хүмүүс амьдрах нийтийн байр болон бусад байшинд байгаа хүн амьдрах зориулалттай сууц орно.	-
<b>Сууцны тусдаа байшин</b>	Нэг болон түүнээс олон өрөөтэй, айл, өрх амьдрах зориулалттай баригдсан, зарим нь дэд бүтцийн хангамжтай (халаалтын систем, усан хангамж, дотроо бие засах газар зэрэг).	-
<b>Нийтийн сууцны байшин доторх сууц</b>	Хоёр, түүнээс олон айл, өрх амьдрахаар, тус тусдаа хаалгатай баригдсан байшин доторхи нэг өрх амьдрах сууц. Тохилог орон сууцанд хоёр, түүнээс олон айл, өрх амьдрах боломжтой, дэд бүтцийн хангамжтай (халаалтын систем, усан хангамж, дотроо бие засах газар зэрэг).	-
<b>Оюутан, сурагчдын нийтийн байр</b>	Боловсролын аль ч түвшинийн оюутан, сурагчид хамтран амьдрахад зориулсан байшин.	-
<b>Нийтийн байр</b>	Ажиллагсад, цэрэг болон нийтээрээ амьдардаг хүмүүсийг хамт амьдрахад зориулсан байшин.	-
<b>Сууцны бус</b>	Анхнаасаа хүн суух зориулалтын бус байшин, түүний нэг хэсэг буюу өрөө тасалгаанд (зориулалтаараа аж ахуйн нэгж, байгууллага байрлахад зориулагдсан гэх мэт) болон	-



	вагончик гэх зэрэгт өрх айл, хүн сууж байгаа бол сууцны бус байшин гэж үзнэ.	
<b>Бусад орон сууц</b>	Тооллогын үед өрх, айл, хүн амын сууж байгаа, сууцны тусдаа байшин, нийтийн сууцны байшин доторх сууц, оюутан сурагчдын нийтийн байр, ажиллагчдын нийтийн байр, нийтийн эзэмшлийн бусад байрнаас бусад байр, сууцыг хэлнэ.	-
<b>Өрөөний тоо</b>	Нийт өрөөний тоонд унтлагын өрөө, амрах болон ажлын өрөө орно.	-
<b>Сууцны талбай</b>	Орон сууцны унтах, амрах, зочин, ажлын өрөөнүүдийн талбайн нийлбэрийг Сууцны талбай гэнэ.	-
<b>Төрийн өмчийн сууц</b>	Төрийн болон төрийн өмч давамгайлсан (төрийн өмч нь 51 хувиас дээш) аж ахуйн нэгж, байгууллагын мэдлийн сууц (сууж байгаа өрх сууцаа хувьчилж аваагүй), гэр, байр үүнд хамрагдана.	-
<b>Хувийн өмчийн сууц</b>	Хүмүүс өөрөө барьсан хувийн орон сууц, нийтийн сууцны байшин дахь хувьчилж авсан орон сууц, мөн хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын (Өмчийнх нь 51 хувиас дээш хувийн өмчтэй) мэдлийн сууц, гэр үүнд хамрагдана.	-
<b>Холимог өмчийн сууц</b>	Төрийн, хувийн холимог өмч(адилхан 50 хувийн өмчтэй)-ийн аж ахуйн нэгж, байгууллагын мэдлийн байр, сууц, гэрийг үүнд хамруулна.	-